

Төслийн ID / Дугаар: P174733

МОНГОЛ УЛС: МАЛЧДЫН ЦАХИМ ХОРШОО ТӨСӨЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГО

Боловсруулсан: Монгол Улсын Засгийн Газар, Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам
(ХХААХҮЯ)

2020 оны 10 сар

ГАРЧИГ

1.	ТАНИЛЦУУЛГА.....	5
2.	БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО БА АРГАЗҮЙ	5
3.	ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	5
3.1.	Төслийн үйл ажиллагаа	5
3.2.	Төслийн үр ашиг хүртэгсэд.....	8
3.3.	Төслийн хамрах хүрээ.....	8
4.	ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГА.....	9
4.1.	Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлого.....	9
4.2.	Монгол Улсын Байгаль орчны бодлого, хууль журмууд	11
4.3.	БОНХМБ-д тусгасан Монгол улсын болон Олон улсын байгууллагуудын шаардлагын завсардлын дүн шинжилгээ.....	14
5.1	Байгаль орчны суурь мэдээлэл.....	19
5.2.	Нийгмийн суурь мэдээлэл.....	21
6.	БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ .	23
6.1	Байгаль орчны болзошгүй нөлөөлөл	23
6.2	Нийгмийн болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ.....	24
6.3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учруулах аюул, түүнийг бууруулах арга хэмжээ 26	
6.4	Мал амьтны амьдрах нөхцлийг сайжруулах арга хэмжээ.....	30
6.5	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамруулах журам.....	31
6.6	Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, байгаль орчны хяналт үнэлгээ	33
7.	ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ	36
7.1.	Төслийг хэрэгжүүлэх байгууллагууд: Үүрэг, Хариуцлага.....	36
7.2.	Төслийн зохион байгуулалтын бүтэц	37
7.3.	БОНХМБ-ын хэрэгжилтийн зохицуулалт	38
7.4.	БОНХМБ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх	38
8.	МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ОРОЛЦОО	40
8.1.	Төслийг Бэлтгэх Үеийн Олон Нийтийн Хэлэлцүүлэг	40
8.2.	Төсөл Хэрэгжүүлэх Явцын Олон Нийтийн Хэлэлцүүлэг.....	43
8.3.	Мэдээллийг Ил Тод Болгох	45

8.4.	Гомдол Шийдвэрлэх Механизм	46
8.4.1.	Гомдол Шийдвэрлэх Механизмын зорилго	46
8.4.2.	Гомдол шийдвэрлэх механизм	46

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Төслийн Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандартуудын хамаарал	9
Хүснэгт 2	Төслийг хэрэгжүүлэхэд хамааралтай Монгол Улсын хуулиуд	11
Хүснэгт 3	Байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлогын завсардлын дүн шинжилгээ	14
Хүснэгт 4	Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ	23
Хүснэгт 5	Төслийн нийгмийн нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ	25
Хүснэгт 6	Хөдөлмөрийн Аюулгүй байдал, Эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээ	26
Хүснэгт 7	Дэд төслийн эрсдлийн зэрэг тогтоох	32
Хүснэгт 8	Барилгын угсралтын үе шатанд хийгдэх хяналт шинжилгээ	34
Хүснэгт 9	Барилгын ашиглалтын үе шатанд хийгдэх хяналт шинжилгээ	35
Хүснэгт 10	Сургалтын хөтөлбөр – сургалтын хэрэгцээний хураангуй	39
Хүснэгт 11	Оролцогч талуудтай урьдчилан Зөвлөлдөх /Олон нийтийн хэлэлцүүлгийн эмхэтгэл	40
Хүснэгт 12	Төслийн олон нийтийн хэлэлцүүлэг	44
Хүснэгт 13	Төслийн мэдээллийг ил тод болгох	45
Хүснэгт 14	Олон Нийтийн Гомдол Шийдвэрлэх нэгжийн бүтэц	47
Хүснэгт 15	Гомдол Хянан Шийдвэрлэх Механизм	48

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1	Төсөл хэрэгжих аймаг	8
Зураг 2	Дэд төслийн үнэлгээ хийх явц	32
Зураг 3	Төсөл хэрэгжүүлэх зохицуулалт	37

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АУ	Ажлын удирдамж
БОАЖЯ	Байгаль орчин, Аялал жуулчлалын Яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОНХМБ	Байгаль орчин, нийгмийн хамгааллын менежментийн бодлого
БОНХС	Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт
БОХШҮ	Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр
БОЭМАБ	Байгаль орчин, Эрүүл Мэнд, Аюулгүй байдал
ГШМ	Гомдол Шийдвэрлэх Механизм
ДБ	Дэлхийн Банк
ДМАЭМБ	Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖАЙКА	Японы Олон Улсын хамтын Ажиллагааны Байгууллага
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МААЭЗЭНТ	Мал аж ахуйн эдийн засгийн Эргэлтийг нэмэгдүүлэх төсөл
МАЭМТС	Монголын Мал, амьтны Эрүүл мэндийг тодорхойлох систем
М&Ү	Мониторинг & Үнэлгээ
МТ	Мэдээлэл Технологи
МХХТ	Мэдээлэл, Харилцаа Холбооны Технологи
НӨБ	Нөлөөлөлд өртсөн хүн/бүлэг
ОНСГБН	Олон нийтийн санал гомдол барагдуулах нэгж
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
ТББ	Төрийн бус байгууллага
ТУЗ	Төслийн Удирдах Зөвлөл
ТХН	Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж
ТХЗ	Төслийн Хөгжлийн Зорилго
ХХААБ	Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХХМТГ	Харилцаа Холбоо, Мэдээлэл Технологийн газар
ХХХ	Хувийн Хамгаалалтын Хэрэгсэл
ЧА	Чиглүүлэгч Агентлаг
ЯНХС	Японы Нийгмийн Хөгжлийн Сан

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХААХҮЯ) нь Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр “Малчдын цахим хоршоо” төслийг зорилтот газруудад хэрэгжүүлж байна. Төслийн зорилго нь дижитал технологи, үйлчилгээг ашиглах замаар зорилтот газруудад алслагдсан малчдын амьжиргаа болон амьдралын чанарыг сайжруулахад оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд ХХААХҮЯ нь дижитал шийдлийг ашиглах замаар шинэлэг арга барилыг хэрэгжүүлж байна.

Энэхүү байгаль орчин нийгмийн хамгааллын менежментийн бодлогын (БОНХМБ) баримт бичгийг төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг таньж мэдэхэд туслах зорилгоор бэлтгэсэн болно. Тус баримт бичгийг суурин судалгаанд үндэслэн тоон баримт үзүүлэлтүүдийг судлах, мөрдөгдөж байгаа бодлого, зохицуулалтын дүрэм журмыг нягтлах, оролцогч талуудтай зөвлөлдөх замаар боловсруулсан.

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО БА АРГАЗҮЙ

Төслийн Байгаль орчин, нийгмийн хамгааллын менежментийн бодлого (БОНХМБ) нь ХХААХҮЯ-ны байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг удирдах арга барилыг бэхжүүлэх зорилготой. “Малчдын цахим хоршоо” төслийн санал болгож байгаа загвар нь “нээлттэй хөтөлбөр”-ийн буюу олон чиглэлийн үйл ажиллагааг хамруулах хөтөлбөрийн шинж чанартай тул төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд одоогоор тодорхой төлөвлөгдөөгүй, байршил нь хараахан товлогдоогүй байна. Энэхүү БОНХМБ нь төслийн үйл ажиллагааг боловсруулж хэрэгжүүлэхтэй холбоотой байгаль орчин, нийгэм, цаг уурын эрсдэл, тохиолдож болзошгүй нөлөөллийг тодорхойлох, тэдгээрийг бууруулах, зохицуулахад чиглэсэн удирдамжуудаар хангахад оршино.

БОНХМБ нь төслийн зорилго, бүрэлдэхүүн хэсгүүдийн зорилтуудад тулгуурлан нөхцөл байдлыг бүхэлд нь дүгнэх, төслийн хүрээнд байгаль орчин, нийгэмд (нутгийн уугуул иргэд, үндэсний цөөнхөд) сөргөөр нөлөөлж болзошгүй дэд төсөл, үйл ажиллагаануудад үнэлгээ хийх аргачлалыг тогтоох, зорилтот бүлгийн хүмүүс болон бусад оролцогч талуудын оролцоотойгоор тохиолдож болзошгүй сөрөг үр дагаваруудыг тодорхойлох, түүнээс зайлсхийх, бууруулах үйл явц, шаардлагуудыг тусгасан болно.

3. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн хөгжлийн зорилт нь дижитал технологи, үйлчилгээг ашиглах замаар зорилтот газруудад алслагдсан малчдын амьжиргаа болон амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Төслөөс хүлээгдэж буй үр дүн:

1. Хөдөөгийн малчдыг цахим хоршооны зохион байгуулалтанд оруулах,
2. Хөдөөгийн малчдад (тархац ба зах зээл) дижитал платформыг ашиглан үйлчилгээ үргэлжлүүлэн авах боломжийг олгох,
3. Хөдөөгийн малчдад тогтвортой мал аж ахуйн менежментийн туршлагыг нэвтрүүлэх,
4. Бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн чадавхи, зах зээлийн харилцаа холбоог сайжруулах зэрэг болно.

3.1. Төслийн үйл ажиллагаа

Төслийн үйл ажиллагаа нь 4 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн 1: Ядуу малчдыг хоршоонд элсүүлэх (1.50 сая ам.дол). Уг бүрэлдэхүүний гол зорилт нь баталгаатай дижитал платформыг (цахим хоршоо) үүсгэж малчдыг мэдээллээр хангах, амьжиргааны үйлчилгээний хүртээмжийг сайжруулах замаар малчдын байгууллагын нийгмийн оролцоог дэмжихэд оршино. Бодит байдал дээр хүн бүхний мэддэг хоршоодтой адил цахим хоршоо нь гишүүдийнхээ бизнесийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд хамтран ажилладаг хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн сайн дурын холбоо юм. Тулгамдсан асуудлуудад хөрөнгө оруулалтын эх үүсвэр, боловсруулах тоног төхөөрөмжийн хүртээмж, тэдний бүтээгдэхүүнийг худалдан авагчийг олох, эсвэл тэдгээрийн тээвэрлэлтийг зохион байгуулах зэрэг хамаарна. Цахим орчинд хурал, шийдвэр гаргах, мэдээлэл солилцох зэрэг нь цахимаар явагдах бөгөөд интернэт платформ нь хоршооны эрэмбэлсэний дагуу хамтарсан арга хэмжээг гишүүддээ зохион байгуулахаар бүтээгдсэн байна. Бэлтгэл ажлын үеэр МХХТ-ийн хүртээмж болон хэрэглээг оролцуулан малчдын дунд байгаа жендерийн ялгаанд дүн шинжилгээ хийж цахим хоршоонд эмэгтэйчүүдийн оролцоог хангах арга замыг боловсруулна. Малчдын дижитал платформд итгэх итгэлцлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд цахим хоршооны удирдлагын бүтэц, бүх оролцогч талуудын харилцаа болон үүрэг, хариуцлага, санал болгох дүрэм, платформоор дамжуулан авах үйлчилгээний хүртээмж болон төлбөр, мэдээллийн аюулгүй байдал зэрэг асуудлыг боловсруулахад төсөл оролцооны аргыг хэрэглэнэ. Удирдлагын бүтцийг боловсруулахдаа платформын санхүүгийн үйлчилгээний тохирох загварыг боловсруулахад анхаарал хандуулах хэрэгтэй. Энэхүү үйл явцад малчид болон бусад талууд оролцох нь малчид болон платформын бусад оролцогчдын хооронд итгэлцлийг үүсгэнэ.

Чадавхийг бэхжүүлэх: Энэ нь малчдыг шинэлэг байдлаар цахим хоршоонд элсүүлэх, технологийн өргөн дамжуулалтын дижитал сувгуудыг ашиглах, хөдөө аж ахуйн үйлчилгээг хүргэх, тэднийг орон нутгийн засаг захиргаатай холбох болон зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд хувийн хэвшлийнхэнтэй бизнесийн холбоо үүсгэхэд нь туслана. Тогтмол хугацаанд ганцаарчлан үүлзэж хамтран ажиллах тус оролцооны арга нь малаа оторлон бэлчээр сэлгэн явах бүхий л үед малчдын хоорондын холбоог хангаж, хүргэх болон үйлчилгээний хүргэлтийн чанарыг сайжруулна. Энэхүү бүрэлдэхүүн нь орон нутагтай холбоотой, соёлд нь тохирсон агуулгыг боловсруулах, дижитал платформоос малчдын хүртэх үр ашгийг хамгийн их байлгахын тулд тэдний бизнесийн үйл явцыг тохируулах зорилготой малчдыг сургах замаар чадавхийг нь бэхжүүлэх, мэдлэг түгээх үйлчилгээг сайжруулна. Төслийн хүрээнд тодорхой заасан цаг хугацаанд видео бүтээх, платформыг ашиглах, боловсруулах аж ахуй нэгжийн чанарын шаардлагыг хангах цөөн тооны малыг нөөц болгон нэгтгэх хамтын ажиллагааны талаар мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулна. Оролцооны аргыг ашиглаж байгаа нь тухайн агуулга нь малчдын хувьд хамааралтай, тэдний мэдлэгийн хэрэгцээнд тохирсон байх боломжийг бүрдүүлдэг. Чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны хэсгийн туршилтад эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, хөдөө аж ахуйн их дээд сургуулиуд, үндэсний зөвлөгөө мэдээлэл, сургалтын төвүүд, ноолуурын салбарт хэрэгжиж байгаа төслүүд болон цуглуулагч, худалдан авагч, боловсруулагчдын сайн туршлага дээр суурилсан одоо байгаа мэдлэгийг ашиглана. Туршилтын хүрээнд бусад холбогдсон үйлчилгээ үзүүлэгчдийг платформыг ашиглан өөрсдийн үйлчилгээг сурталчлах болон платформын зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээнд өөрсдийн зорилгод нийцүүлэн платформыг хэрэглэх хэрэглээг нь нэмэгдүүлэх чиглэлээр чадавхижуулна.

Дижитал үйлчилгээний багц: Төслийн хүрээд дижитал үйлчилгээний багцыг боловсруулж, түгээхэд оролцооны аргыг ашиглана. Малчдын оролцоо, олон удаагийн санал зөвлөмжийг ашиглан төслийн хүрээнд орон нутгийн хэрэгцээнд нийцсэн, тохирох интерфэйсийг зохиохоор төлөвлөсөн Дижитал Грийнтэй хамтран дижитал үйлчилгээний багцыг боловсруулна. Энэхүү

дигитал үйлчилгээний багцад орхигдсон, алслагдсан малчдад хүрэх, тогтвортой мал аж ахуйн менежмент, ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сурталчлах, үнэ чанар болон малчид өөрсдөд нь хэрэгтэй гэж тодорхойлсон бусад мэдээллийг түгээх зэрэг дигитал шинэлэг санаачлагуудыг ашиглана. МХХТ-ийн шийдэлд мобайл аппликейшн, онлайн болон оффлайн видео, дуут бичлэг болон нэвтрэх боломжтой олон төрлийн төхөөрөмж, сувгууд (ухаалаг утас таблет, компьютер, туламжийн утас гэх мэт)-аас малчид тохиромжтой гэж тодорхойлсон, сонгоход тохиромжтой хандалттай сувгуудыг санал болгоно. Энэ дэд бүрэлдэхүүн нь малчид, мал аж ахуйн судлаачид, түс салбарын мэргэжилтэнүүд хамтарсан **Цахим сургалтын төв**-ийг үүсгэх ба энэ хүрээнд мал аж ахуйн бүтээмж болон мал үржүүлгийн талаарх нутгийн үугуул иргэдийн мэдлэгийн цахим номын санг үүсгэнэ. Мөн орон нутгийн түвшинд холбогдох зөвлөх үйлчилгээ үзүүлдэг одоо байгаа байгууллагуудтай тухайлбал, ХААИС болон Ноолуурын салбарын дугуй ширээний хэлэлцүүлэг (НСДШХ)-тэй хамтран ажилладаг бусад байгууллагуудтай түншлэл үүсгэх төлөвлөгөөтэй байна.

Бүрэлдэхүүн 2: Малчдыг зах зээлтэй холбох (1.00 сая ам.дол) Энэхүү бүрэлдэхүүн нь техникийн түслалцаа, энгийн байгууламж, бага хэмжээний үр өгөөжтэй дэд бүтэц, техникийн түслалцаа үзүүлэгчдээс өндөр чанартай үйлчилгээ авах байгууллагын гүйцэтгэлийн шалгуурт нь суурилсан цахим хоршоонд эргэлтийн хөрөнгө, бага хэмжээний үр өгөөжтэй дэд бүтцийг худалдан авах, хамтарсан үйлдвэрлэл болон зах зээлийн үйл ажиллагааны эргэлтийн хөрөнгө гэх мэт үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Бүтээмжийн арга нь ихэвчлэн одоо байгаа төрийн болон хувийн хэвшлийн оролцогчидын хооронд түншлэл байгуулах замаар явагдах ба цахим хоршоодын гол төвүүд дэх олон санал санаачлагуудыг нэгтгэх замаар шинэлэг үйл ажиллагааг зохион байгуулах ажлууд багтана.

Дигитал санхүүгийн үйлчилгээ: Төслийн хүрээнд алслагдсан малчдад хүрч очих үйл ажиллагаа сайжруулах зорилгоор цахим хоршооны платформ дээрх тогтвортой мал аж ахуйн санхүүжилтийн бүтээгдэхүүний загварыг турших болон түгээхэд одоо байгаа дигитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран ажиллана. Мал аж ахуйн дигитал санхүүжилт нь бусад оролцогчид дахин ашиглах боломжтой байх ёстой.

Мал аж ахуйн үйлчилгээ: Платформыг ашиглан үйлчилгээ үзүүлэхийн тулд төрийн болон хувийн хэвшлийн оролцогчидтой түншлэл үүсгэх шаардлагатай. Оролцогчдын үйлчилгээнд малын эрүүл мэндийн үйлчилгээ, зах зээлийн мэдээлэл (үнэ ханш, боловсруулалтын үйл явцын болон тэдний шаардлагын талаарх мэдээлэл), цаг агаар болон цаг уурын зөвлөгөө, дигитал төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, хоол тэжээлийн мэдээлэл эсвэл “Нэг эрүүл мэнд” нийгмийн арга хэмжээ зэрэг багтана. Нэгдсэн интерфэйс болон салангид байгаа үйлчилгээнүүдийг нэг цэгт төвлөрүүлсэнээр төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний нэгдмэл байдлыг хангаж чиглүүлэхэд туслана.

Зах зээлийн үйлчилгээ: Төслийн хүрээнд мал амьтны амьдрах орчин нөхцлийн хангах, тогтвортой мал аж ахуйн түршлага, бэлчээрийн органик мал аж ахуй, шударга худалдаа болон хариуцлагатай эх үүсвэрийн механизмыг сурталчлах замаар өндөр үр ашигтай сүлжээнд оролцох цахим хоршоодыг бэлтгэнэ. Дэмжлэг нь зорилтот бүлгийн мал аж ахуйн үйлдвэрлэгчдэд чиглэх ба үүнд (i) тэдний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, (ii) халамжийн системийн сүлжээ болон хариуцлагын талаарх түршлагыг шинжлэх ухаанд суурилсан арга барилтай болгох, ба (iii) амьтны гаралтай дээд зэргийн чанартай ширхлэгт бүтээгдэхүүнийг борлуулахын тулд гуравдагч судалгааны байгууллагаар баталгаажуулан гэрчилгээжүүлэх үйл явцийг бий болгох.


Бүрэлдэхүүн 3: Төсөл Хэрэгжүүлэх Дэмжлэг (US\$ 230,000). Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь төслийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлнэ. Энэ нь Дижитал Грийний төслийн үйл ажиллагаа, дижитал үйлчилгээ үзүүлэгчид болон орон нутгийн чиглүүлэгч байгууллагуудын үялдаа холбоог дэмжинэ. Төслийн Менежментийн нэгж нь ХХААХҮЯ-ны удирдамжийн дагуу хэрэгжиж буй төслийн үүрэг гүйцэтгэгчийн чиг үүрэг, байгаль орчин нийгмийн хамгааллын менежмент, хяналт шинжилгээ үнэлгээг үр дүнтэй явуулах шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмжтэй байна. Уг бүрэлдэхүүн удаан хугацааны ажилтан, зөвлөх, үйл ажиллагааны зардал, техникийн туслалцаа (ТТ), сургалт, хяналт шинжилгээ ба үнэлгээний үйл ажиллагаа, суурь болон эцсийн үр дүнгийн үнэлгээ, мэдээлэл түгээх болон жилийн аудитийн үйл ажиллагаануудыг санхүүжүүлнэ.

3.2. Төслийн үр ашиг хүртэгсэд

Төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны үр ашгийг дараах дөрвөн бүлгийн хүмүүс хүртэнэ. Нэгдүгээрт, алслагдмал нутагт амьдардаг цөөн малтай малчид, ядуу болон бусад эмзэг өрхүүд. Хоёрдугаарт, малчдын бүлэг, бэлчээр ашиглагчдын болон үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо, байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага (ИНБ) зэрэг олон нийтийн байгууллагууд, Гуравдугаарт, алслагдмал нутагт байгаа мал аж ахуйн хөгжлийн төвүүд, малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг төлөөллүүд, тухайлбал хувийн мал эмнэлэг, дижитал санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэгчид, Дөрөвдүгээрт, зорилтот аймаг/сумдад хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг аймаг/сум (Аймгийн болон Сумын захиргааны байгууллагууд) -ын захиргаа, орон нутгийн ажилтнууд байна.

3.3. Төслийн хамрах хүрээ

Төсөл нь дараах аймгуудад хэрэгжинэ:



Зураг 1 Төсөл хэрэгжих аймаг

- Өвөрхангай аймгийн Арвайхээр сум (2019 оны байдлаар 32891 хүн амтай)
- Өвөрхангай аймгийн Баянгол сум (2019 оны байдлаар 3830 хүн амтай)
- Ховд аймгийн Дарви сум (2019 оны байдлаар 3022 хүн амтай)
- Ховд аймгийн Мөст сум (2019 оны байдлаар 3141 хүн амтай)
- Архангай аймгийн Батцэнгэл сум (2019 оны байдлаар 3759 хүн амтай)
- Архангай аймгийн Цэнхэр сум (2019 оны байдлаар 5933 хүн амтай)
- Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум (2020 оны байдлаар 3361 хүн амтай)
- Баянхонгор аймгийн Бууцагаан сум (2020 оны байдлаар 3694 хүн амтай)

Тус төслөөс 2500 өрх буюу 8500-аас 9000 малчид үр ашиг хүртэх бөгөөд тэдний 40 % нь ядуу, 50% нь эмэгтэйчүүд байна.

4. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГО БА ЗОХИЦУУЛАЛТЫН ШААРДЛАГА

4.1. Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлого

Энэхүү төсөл нь Дэлхийн Банкны Байгаль орчин, Нийгмийн хамгааллын бодлогоор зохицуулагдах бөгөөд уг төслийн хүрээнд мөрдөх байгаль орчин, нийгмийн хамгааллын стандартуудын хамаарлыг Хүснэгт 1-т нэгтгэн харууллаа.

Хүснэгт 1 Төслийн Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандартуудын хамаарал

Но.	Байгаль орчин, нийгмийн хамгааллын Стандарт	Хамаарна эсвэл хамаарахгүй	Дүн шинжилгээ
1	БОНХС1. Байгаль орчин, нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент	Хамаарна	Энэхүү стандартад заасны дагуу ХХААХҮЯ нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдлийг үнэлэх, удирдах, хяналт тавих шаардлагатай.
2	БОНХС2. Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрийн нөхцөл	Хамаарна	Төслийн одоогийн загварт төслийн үйл ажиллагааны хүрээнд томоохон хэмжээний барилгын ажил гүйцэтгэхээр тусгагдаагүй бөгөөд олон ажилчдыг авч ажиллуулахгүй. БОНХС2 нь төсөлд оролцож байгаа цөөн тооны, орон нутгийн барилгын ажилчид болон үндсэн, гэрээт мэргэшсэн боловсон хүчинд хамаарна.
3	БОНХС3. Нөөцийн үр ашиг, бохирдлоос урьдчилан сэргийлэх менежмент	Хамаарна	Тоног төхөөрөмжийг суурилуулах эсвэл барилга байгууламжийг засаж сайжруулахтай холбоотой гүйцэтгэх бага хэмжээний барилгын ажил нь тоос шороо, бохир ус, хатуу хог хаягдлыг үүсгэнэ. Мал аж ахуйн үйлдвэрлэл, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх байгууламжийг ашиглах явцад нөөцийн эх үүсвэрийн хэрэглээ (ялангуяа ус), химийн бодисын менежмент, хатуу хог хаягдал үүсгэх, бохир ус болон агаарт олон төрлийн бодис уурших зэрэг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
4	БОНХС4. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Хамаарна	Энэхүү стандарт нь төслийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан тооцож түүнээс зайлсхийхэд чиглэнэ. Төсөл хэрэгжих газар, түүний ойролцоо амьдардаг оршин суугчдад барилгын ажлын хэмжээ, гүйцэтгэлийн чанараас шалтгаалан

			<p>тодорхой хүндрэл бэрхшээл учруулахгүй бөгөөд экосистемд сөргөөр нөлөөлөхгүй. Барилга угсралтын явцад түр зуурын, орон нутгийн шинжтэй дуу чимээ, тоос шороо, хог хаягдал үүсгэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөллийг барилгын ажлын сайн туршлагыг нэвтрүүлснээр хялбархан арилгах боломжтой. Барилгын ажилд цөөн тооны орон нутгийн иргэдийг ажиллуулна. Тиймээс ажилчдын кэмп, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн эсвэл жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой ноцтой эрсдэл үүсэхгүй. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны хүрээнд төслийн үр ашиг хүртэгчидтэй хийх уулзалтыг дэмжих, мэргэжилтнүүд зорилтот аймгуудад томилолтоор ажиллах тохиолдолд КОВИД19 халдварт өвчин дамжих эрсдлийг бий болгож байна. Иймд энэхүү стандарт халдварыг дамжуулахгүй байх зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээг төслийн загвар, үйл ажиллагааны журамд нийцүүлэхэд чухал ач холбогдолтой. Мөн түүнчлэн, малын тоо толгой нэмэгдсэнээс шалтгаалан өвчлөлийн эрсдлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээг төслийн баримт бичигт тусгана.</p>
5	БОНХС5. Газрын дүр төрхийг өөрчлөх, газар ашиглалтыг хязгаарлах	Хамаарахгүй	Төсөл нь газар худалдан авах, газар эзэмших эрхтэй холбоотой аливаа үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.
6	БОНХС6. Биологийн олон янз байдлыг хамгаалах болон байгалийн амьд нөөцийн тогтвортой менежмент	Хамаарна	Энэхүү стандартын зорилго нь биологийн олон янз байдал, амьдрах орчныг хадгалж хамгаалах, байгалийн амьд нөөцийн тогтвортой менежментийг дэмжихэд оршино. Төслийн хүрээнд байгалийн амьд нөөцийн анхан шатны үйлдвэрлэлийн нэг хэлбэр болох мал аж ахуйн тогтвортой менежментэд анхаарна. Монгол орны хувьд мал аж ахуй эрхлэгчид нь цөөн тоогоор нэгдсэн, алслагдмал газарт амьдардаг явдал нь төслийн хүрээнд дэмжлэг туслалцаа авах үйлдвэрлэгчдийн тоог хязгаарлаж байна. Ийм учраас хуримтлагдсан эрсдэл болон нөлөөлөл бага байх боломжтой.
7	БОНХС7. Уугуул иргэд/ Африкийн Өмнөд Сахар орчмын нутгийн уугуул иргэд түүхэндээ танигдалгүй үлдсэн.	Хамаарна	Ховд аймгийн Мөст суманд Захчин хүмүүс байх тул энэхүү стандарт хамаарна. Шалгаруулах явцад нийгмийн нөлөөллийн түргэвчилсэн үнэлгээ хийнэ. Үндэсний цөөнх төслийн талбайд оршин суугаа тохиолдолд оролцогч талуудтай хийх уулзалтыг орон нутагт тохиромжтой хэлбэрээр зохион байгуулна.
8	БОНХС8. Соёлын биет өв	Хамаарахгүй	Төслийг боловсруулах явцад олдсон мэдээлэл болон төслийн загварт үндэслэн энэхүү стандартыг хамаарахгүй гэж үзсэн. Төслийн хүрээнд барих жижиг байгууламжууд нь одоо байгаа аж ахуйн нэгжүүдийн эзэмшлийн газарт баригдана. Хуулиар хамгаалагдсан уламжлал соёлын биет өв, хүлээн зөвшөөрөгдсөн түүх, соёлын өвийн дурсгалт газар,

			тэдгээрийн ойролцоо нутаг дэвсгэрт дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх магадлал бага. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглахгүй тул соёлын биет бус өвд ч мөн адил эрсдэл учруулах магадлал бага байна.
9	БОНХС9. Санхүүгийн зуучлал	Хамаарахгүй	Энэ стандарт нь тус хэрэгжүүлэх төсөлд хамаарахгүй бөгөөд төслийг ХХААХҮЯ хэрэгжүүлж, техникийн туслалцааны агентлагаар Дижитал Грийн ажиллана.
10	БОНХС10. Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийг ил тод болгох	Хамаарна	МАНЭЭЭНТ ТХН нь төслийн оролцогч талуудтай илэн далангүй, хариуцлагатай хамтран ажиллахад анхаарах бөгөөд энэ нь төслүүдийн байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангаж, төсөлд хүлээлгэх итгэлийг нэмэгдүүлнэ. Стандартын дагуу ТХН нь бусад сонирхогч талуудын төслийн үйл ажиллагаанд оролцох идэвхитэй хандлагыг бий болгох зорилгоор Оролцогч талуудтай харилцах, зөвлөлдөх төлөвлөгөө (ОТХЗТ) боловсруулж хэрэгжүүлнэ. Тус хандлага нь төслийн оролцогч талууд, нөлөөлөлд өртсөн бүлгүүдийг тодорхойлох, түүнчлэн төслийн үйл ажиллагааны бүтээлч харилцааг үүсгэж хадгалахад чиглүүлнэ.

Үүнээс гадна Дэлхийн Банкны Группын Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдал (БОЭМАБ)-ын дараах удирдамжуудыг уг төсөлд хамааралтай гэж үзнэ:

- БОЭМАБ-ын Ерөнхий Удирдамж
- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулахад зориулсан БОЭМАБ удирдамж
- Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулсан БОЭМАБ удирдамж
- Мах, махан бүтээгдэхүүн боловсруулахад зориулсан БОЭМАБ удирдамж
- Нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулсан БОЭМАБ
- ОУСК-ийн Сайн Түршлагын Зөвлөмж: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд Мал амьтны амьдрах нөхцлийг хангах

4.2. Монгол Улсын Байгаль орчны бодлого, хууль журмууд

Монгол Улс байгаль орчны үнэлгээ, менежментийн цогц бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлсэн билээ. Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан амьдрах нөхцлийг хангахын тулд байгаль орчны чанарыг хадгалан хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийг удирдах зорилгоор бодлого, стратеги, хууль тогтоомжууд гаргаж, хэрэгжүүлж байна. Монгол Улсын байгаль орчны талаар баримтлах бодлогын үндсэн зарчим бол эдийн засгийн хөгжил нь байгалийн нөөцийг олборлох, ашиглахын зэрэгцээ агаар, ус, хөрсний бохирдлыг хянаж, тэнцвэртэй байдлыг хадгалах явдал юм. 1996 оны 4-р сард улс орны тогтвортой хөгжилтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үндэсний Зөвлөлийг байгуулсан. Төрөөс баримтлах стратеги нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд тогтвортой, элбэг хангалуун нийгмийн хөгжлийг зорих бөгөөд үүнд урт хугацааны тогтвортой хөгжлийг тодорхойлох хүчин зүйл бол тус улсын иргэд гэдгийг онцлон тэмдэглэсэн. Төслийг хэрэгжүүлэхэд хамааралтай Монгол Улсын гол хуулиудыг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2 Төслийг хэрэгжүүлэхэд хамааралтай Монгол Улсын хуулиуд

Дугаар.	Хуулийн нэр	Шаардлага	Төсөлд хамаарах эсэх
1	Байгаль Орчинд Нөлөөлөх байдлын тухай хууль (2012)	ХАА-н салбарт хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэж болно.	Хамаарна
2	Байгаль Орчныг Хамгаалах тухай хууль (1995)	Нийгэм, эдийн засгийн хөгжил нь байгаль орчныг хамгаалж, тэнцвэртэй байдлыг хадгалах боломжтой.	Хамаарна
3	Улсын Тусгай Хамгаалалттай Газрын тухай хууль (1994)	Тусгай хамгаалалттай газрууд, тэдгээрийн хамгаалалтын бүсэд зөвхөн хуулиар тодорхойлсон үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг.	Хамаарна
4	Соёлын Өвийн тухай хууль (2014)	Соёлын биет болон биет бүс өвийг их хэмжээний газар шорооны ажлыг хийхээс өмнө хамгаалалтад авч судлах ёстой.	Хамаарахгүй
5	Хог, хаягдлын тухай хууль (2017)	Хог, хаягдлаас үүсч болзошгүй эрсдлийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах, хамгийн бага түвшинд хүргэх болон зохицуулах шаардлагатай.	Хамаарна
6	Усны тухай хууль (2012)	Усны нөөцийг зөв зохистой ашиглах, түүний хэрэглээг зохицуулах ёстой.	Хамаарна
7	Хөдөлмөрийн тухай хууль (1999)	Ажилтны хөдөлмөрийн эрх, үүргийг хүндэтгэн үзэх, ажилчдыг аюулгүй, эрүүл орчинд ажиллах нөхцлөөр хангах ёстой.	Хамаарна
8	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)	Энэхүү хууль болон түүний шаардлага, стандартыг бүх ажлын байранд мөрдөх ёстой.	Хамаарна
9	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)	Эрэгтэй, эмэгтэй хүмүүс аливаа харилцаанд тэгш эрхтэй.	Хамаарна
10	Малын эрүүл мэндийн тухай хууль (2017)	Энэхүү хууль нь малын эрүүл мэндийн хамгаалал, мах, арьс шир зэрэг малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйг хангахад чиглэнэ.	Хамаарна

Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний шаардлагыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012) -иар зохицуулдаг. Энэхүү хуулийн зорилт нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийг ашиглах явцад үүсэх байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх,

хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр батлахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

БОНБУ-ний тухай хуулиар 2 төрлийн БОНБУ-г тусгасан. Үүнд:

- (i) БОНБЕУ (ерөнхий үнэлгээ) – БОНБЕУ-ийг хийлгэхийн тулд төсөл хэрэгжүүлэгч нь БОАЖЯ-нд (эсвэл аймгийн БОАЖГ-т) төслийн ТЭЗҮ, техникийн дэлгэрэнгүй мэдээлэл, зураг болон бусад мэдээллийг багтаасан төслийн товч танилцуулгыг хүргүүлнэ. БОНБЕУ нь дараах дөрвөн зүгнэлтийн аль нэгэнд хүргэж болно. Үүнд: (i) БОНБНУ шаардлагагүй, (ii) тухайн төслийг тодорхой нөхцөлтэйгээр хэрэгжүүлж болно, (iii) БОНБНУ шаардлагатай, эсвэл (iv) төслийг хэрэгжүүлэхийг цуцлах. БОНБЕУ нь үнэ төлбөргүй хийгдэх бөгөөд ихэвчлэн ажлын 14 хоног үргэлжилдэг.
- (ii) БОНБНУ (нарийвчилсан) – хамрах хүрээг БОНБЕУ-ээр тодорхойлдог. БОНБНУ-ний тайланг БОАЖЯ-наас олгосон эрх бүхий аж ахуйн нэгж/компани тусгай журмын дагуу боловсруулж батлуулах ёстой. Уг аж ахуйн нэгж нь БОНБНУ-ний тайланг боловсруулж БОАЖЯ-нд (эсвэл Аймгийн ЗДТГ) хүргүүлнэ. Уг төслийн БОНБЕУ-г хийсэн шинжээч мэргэжилтэн 18 хоногийн дотор БОНБНУ-ний тайланг судлан тойм дүгнэлт гаргаж, БОАЖЯ-д (эсвэл Аймгийн ЗДТГ) танилцуулах ёстой. Шинжээчийн дүгнэлтийг үндэслэж БОАЖЯ (эсвэл Аймгийн ЗДТГ) уг төслийг батлах, эс зөвшөөрөх тухай шийдвэр гаргана.
- (iii) БОНБНУ нь дараах бүлгүүдийг агуулна: (i) Байгаль орчны суурь мэдээлэл; (ii) Төслийн хувилбарууд; (iii) Нөлөөллийг багасгах, арилгах зөвлөмж; (iv) Сөрөг нөлөөлөл ба түүний үр дагаврын цар хүрээ, тархалтын дүн шинжилгээ; (v) Эрсдлийн үнэлгээ; (vi) Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө; (vii) Байгаль орчны мониторингийн хөтөлбөр; (viii) Төслийг хэрэгжүүлэх эсэх талаар оршин суугчдын санал.

Хэрэгжих төслийн үйл ажиллагааны байршил, төрөл, хэмжээнээс хамаарч БОНБУ хийлгэх шийдвэрийг Байгаль орчин, аялал жуулчлалын Яам (БОАЖЯ) эсвэл Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар гаргана. Энэхүү төслийн хүрээнд нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлага үүсэхгүй.

Байгаль орчны хяналт шинжилгээ хийх шаардлага нь хүрээлэн буй орчны агаар, ус, орчны дуу чимээ, хөрсний чанарын чиг хандлага, мөн тэдгээрийн чанарт бохирдуулагч бодис, антропогенийн үйл ажиллагаа, эсвэл хог хаягдлыг боловсруулалт (хяналт шинжилгээний нөлөөлөл) зэрэг нь хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох явдал юм. Төслийн үйл ажиллагаанаас бий болох хаягдал, бохирдуулагч нь төслийн зорилтот газар, түүний эргэн тойрны агаар, газрын доорхи ба гадаргын ус, нууранд хэрхэн нөлөөлж байгаад мониторинг хийх шаардлагатай. Төсөлтэй холбоотой үйл ажиллагааг эхлэхээс өмнө орчны чанарыг тодорхойлох зорилгоор мониторинг хийх бөгөөд энэ нь нөлөөллийн хяналттай харьцуулах арга хэрэгсэл болдог. Түүнчлэн үүнийг онгон байгальд гэнэтийн өөрчлөлт гарсан эсэхийг шалгахад ашигладаг. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, Орчны Шинжилгээний газар (ЦУОШГ) нь хүрээлэн буй орчны чанарыг хянах зорилгоор ус, агаар, хүчил хуримтлагдсан эсэх, хөрс, орчны цацраг идэвхт бодис, тоосжилт, хүхрийн хийн үзүүлэлтүүдийг тодорхойлж орчны хяналт шинжилгээг хийх үүрэгтэй. Том хотууд дахь лабораториуд нь агаар, ус, хөрсний чанар, цацрагийн түвшинг тогтмол хэмжиж, цахилгаан станц, тээврийн хэрэгслээс гарах бохирдлын эх үүсвэрийг хянах; байгаль орчны үнэлгээний талаар шаардлагатай хяналт шинжилгээний ажлыг явуулах; бусад байгаль орчны хяналтын байгууллагуудтай хамтран үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлуулах, устгах үйл явцыг хянах үүрэгтэй ажилладаг.

4.3. БОНХМБ-д тусгасан Монгол улсын болон Олон улсын байгууллагуудын шаардлагын завсардлын дүн шинжилгээ

Төслийн БОНХМ-ийг хэрэгжүүлэхэд баримтлах Монгол улсын болон олон улсын байгууллагуудын тавьдаг шаардлагуудыг харьцуулан завсардлын дүн шинжилгээ хийхэд тэдгээрийн хооронд тодорхой зөрүү завсардал гарч байгаа бөгөөд эдгээр шаардлагуудын дүн шинжилгээ, завсардлыг нөхөх арга хэмжээг Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3 Байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлогын завсардлын дүн шинжилгээ

Сэдэв	Зөрүү (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний шаардлагатай харьцуулахад)	Зөрүүг арилгах арга хэмжээ
Байгаль орчны үнэлгээний хүрээ	Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамардаг (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 1)	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь байгаль орчин, хөдөлмөрийн нөхцөл, хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нөөцийн үр дүнтэй байдал, тогтвортой менежмент, албадан нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэд зэрэг асуудлуудыг хамарна.
	Тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд хийх үйл ажиллагаанд нөлөөллийн үнэлгээ хийнэ (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 1)	Дэд төслүүдийн үнэлгээ заавал хийгдэх
Хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны аюулгүй ажиллагаа	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008) нь олон улсын конвенц, бусад баримт бичгийн шаардлагатай нийцэх ба ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхойлдог. Эдгээр хууль тогтоомжийг бүх ажил олгогчид дагаж мөрдөх ёстой. Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл мэндтэй холбоотой эрсдлийг арилгах арга хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгайлан заагаагүй (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн	Төслийн хүрээнд хэрэгжих дэд төслүүд оролцогч талуудтай харилцах стратеги, хөдөлмөрийн удирдлагын журам, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх заалтууд орсон.

	хүрээний стандарт 2)	
Нөөцийн үр дүнтэй ашиглалт, бохирдлыг хянах	Агаар, Ус, Хог хаягдлын тухай хуулиудад эдгээр нөөцтэй холбоотой шаардлагуудыг дэлгэрэнгүй тусгасан байдаг. Гэсэн хэдий ч бохирдолтой холбоотой заалт, зохицуулалтууд төдийлөн байдаггүй (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 3).	Дэд төсөлд байгаль орчны анхан шатны үнэлгээ хийх явцад байгалийн нөөцийг ашиглахтай холбоотой асуудлыг авч үнэлэх ба Дэлхийн Банкны холбогдох заавар, журмаар хангана.
Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой тухайлсан хууль байхгүй (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 4).	Тухайн орон нутаг, ажлын байран дахь Ковид-19-н тархалтыг багасгах, бусад өвчлөлийг бууруулахтай холбоотой заалтууд төслийн байгаль орчин, нийгмийн хүрээний баримт бичигт орсон.
Албадан нүүлгэн шилжүүлэлт	Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой үндэсний хууль тогтоомж байхгүй. Газрын тухай хуулиар өмчлөл, эзэмшилтэй холбоотой асуудлыг зохицуулах ба малчид сумын удирдлагатай газар ашиглах, өмчлөх гэрээ байгуулдаг. Шинээр газар ашиглах хүсэлтийг сумын ИТХ-д гаргаж сумын газар ашиглалтын төлөвлөгөөнд оруулж батлуулдаг ба энэхүү журмыг төслийн явцад мөн баримталж ажиллана. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд амьдарч буй малчдын газар ашиглах эрх албажаагүй байдаг ба өвөлжөө, хаваржаа ашиглах гэрчилгээтэй байх нь бий. Уламжлалт газрын эрхийг газар ашиглалтын төлөвлөгөөнд авч үздэг боловч хууль тогтоомжоор баталгаажуулж байгаагүй. Нийтийн хэрэгцээнд зориулж газар нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой хуулийн төслийг Дэлхийн Банкны стандарт шаардлагад нийцүүлэн	Газар авах, газрын эрхтэй холбоотой аливаа үйл ажиллагааг төсөл санхүүжүүлэхгүй.

	<p>боловсруулсан боловч хараахан батлагдаагүй байна. Уг хууль батлагдсан тохиолдолд байгаль орчин, нийгмийн хүрээний баримт бичгийг өөрчлөх шаардлагатай (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 5).</p>	
<p>Биологийн олон янз байдал, нөөцийн тогтвортой менежмент</p>	<p>Монгол Улсад амьтны эрх, тогтвортой мал аж ахуйн салбартай холбоотой аливаа хууль тогтоомж байхгүй (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 6).</p>	<p>Байгаль орчин, нийгмийн хүрээний баримт бичигт Дэлхийн Банк, Олон улсын санхүүгийн корпорацийн амьтны сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой журам, холбогдох заалтуудыг тусгасан. Түүнчлэн биологийн олон янз байдалд чухал ач холбогдолтой газар явуулах үйл ажиллагааг дэмжихгүй байх тухай нөхцлүүд туссан.</p>
<p>Уугуул иргэд</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулинд аливаа хүнийг гарал үүсэл, үндэс угсаа, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүй гэсэн заалт байдаг боловч үндэсний цөөнхийн талаар тухайлсан хууль, тогтоомж байхгүй. Албан бичиг хэрэгцээ, сургалтад Халх хэлийг ашигладаг (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 7).</p>	<p>Ардчилсан, чөлөөт зарчимд тулгуурласан уулзалтыг хийх замаар төслийн үйл ажиллагаанд нутгийн уугуул иргэд, үндэсний цөөнхийг бүрэн хамруулна. Ингэхдээ орон нутгийн хэл, соёл, зан заншилд нийцсэн байдлаар зохион байгуулна.</p>
<p>Соёлын өв</p>	<p>Монгол Улсад Соёлын өвийг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиуд бий. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар түүний орчны бүсэд зөвшөөрөгдөх болон үл зөвшөөрөгдөх үйл ажиллагааны талаар тодорхойлсон байдаг. Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар соёлын биет өвийг бүртгэх, хамгаалахтай холбоотой заалтууд тодорхойлогдсон</p>	<p>Соёлын өвийг тодорхойлох, бүртгэх, хамгаалахтай холбоотой ажилд оролцогч талуудын дэмжлэгийг төслийн зүгээс дэмжинэ. Аливаа соёлын өвд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй үйл ажиллагааг төслөөс санхүүжүүлэхгүй. Төслийн олдвор олохтой холбоотой журмыг мөн төслийн үед мөрдөнө.</p>

	байдаг.	
Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоо	Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн шатанд олон нийтийн хэлэлцүүлэг шаарддаггүй (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 1 ба 10).	Ерөнхий үнэлгээний дүгнэлтээс өмнө олон нийтэд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусгах.
	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам бий (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 10).	Олон нийтэд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусгах.
Мэдээллийн ил тод байдал	Үнэлгээний тухай хуулинд энэ талаар тодорхой заалт байхгүй (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 10).	Төслийн байгаль орчин, нийгмийн хүрээний баримт бичиг болон дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө нь олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөөг дэлгэрэнгүй тусгана.
Тайлагнал	Үнэлгээний тухай хуулиар байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан бэлтгэх ёстой (Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээний стандарт 1 ба 10).	Төслийн байгаль орчин, нийгмийн мониторингийн үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Төслийн зүгээс ДБ-ны БОНХБ БОНХС5 ба БОНХС8-д заасан заалтуудыг өдөөсөн байж болзошгүй дэд төслийн ямар ч үйл ажиллагааг дэмжихгүй. Орон нутгийн иргэд, байгууллагыг эдийн засгийн хувьд буюу биет байдлаар нүүлгэх шилжүүлэхэд хүргэх, бусдын газар, өмчид сөрөг нөлөө үзүүлэх бүх дэд төслийн саналыг шалгаруулалтын шатанд хасна. Мөн соёлын өвд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагааг шалгаруулалтын шатанд сонгохгүй.

БОНБУ-ний тухай хуульд зааснаар байгаль орчны үнэлгээний хамрах хүрээ нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг л үнэлэхээр хязгаарлагдсан бол нийгмийн нөлөөллийг хэрхэн үнэлэхийг БОНБУ-ны олон нийтийн оролцоог хангах журамд тусгасан байна. Ерөнхий БОНБУ-ний хувьд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд БОНБҮ-ний үр дүнгийн талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгахыг шаарддаг бөгөөд шийдвэрийг байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын вэбсайтад тавьж олон нийтэд нээлттэй мэдээлэх ёстой. Нарийвчилсан БОНБУ-ний хувьд нөлөөллийг тодорхойлох, харьцуулах, үнэлэхэд олон нийтийн оролцоог хангах шаардлагатай бөгөөд нарийвчилсан үнэлгээний үр дүнгийн талаархи олон нийтийн хэлэлцүүлгийг (техникийн бус дүгнэлтийг) 15 хоногийн хугацаанд баг эсвэл Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын түвшинд хийх шаардлагатай байдаг. БОНБҮ-ийн дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулахад олон нийтийн оролцоог хангах шаардлагатай ба нөлөөлөлд өртсөн хүмүүст БОМТ-ний хэрэгжилтийн талаар жил бүр мэдээлэх ёстой. Хууль журманд тусгагдсан олон нийтийн оролцоонд тавих шаардлагууд нь хэт ерөнхий байгааг харгалзан БОНХМБ нь БОНХС10-д дагуу техникийн бус дүгнэлт, зөвлөлдөх болон шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах зэрэг

мэдээллийг ил тод байлгах чиглэсэн төслийн оролцогч талуудын оролцооны талаар нэмэлт удирдамж өгнө.

Төслийн нийгмийн нөлөөлөлтэй холбоотой хууль тогтоомж Монгол Улсад газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой тусгайлсан хууль тогтоомж байхгүй. Монгол Улсын Газрын тухай хуулиар тодорхой ангилалын газрыг өмчлөх, эзэмших эрхийг тодорхойлдог бөгөөд сумын Засаг даргад малчдын бүлгүүдтэй газар ашиглах гэрээ байгуулах эрхийг олгодог. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сумын Засаг даргын өргөн барьсан орон нутгийн газрыг төрөл бүрийн зориулалтаар ашиглах хүсэлтийг тусгасан сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг батлах эсвэл татгалзах эрхтэй. Төслийг үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад энэхүү журмыг дагаж мөрдөнө. Тусгай хамгаалалттай газрын тогтоосон бүсэд эсвэл түүний ойр орчмын бүсэд бэлчээр ашиглаж байгаа малчдын дийлэнх нь албан ёсны газар эзэмших эрхгүй боловч зарим нь өвөлжөө, хаваржааны бэлчээрийн газрыг тодорхой хугацаа, нөхцөлтэйгээр ашиглах гэрээ байгуулах боломж хуулиар баталгаажсан байдаг. Сумдад газар зохион байгуулалтын төлөвлөгөө байдаг боловч энэ төлөвлөгөө нь малчдын бэлчээрийн газрыг эзэмших, өмчлөх албан ёсны байр суурийг баталгаажуулдаггүй. Монгол Улс иргэн аж ахуйн нэгжийн ашиглаж, эзэмшиж, өмчилж байгаа газрыг төрийн болон олон нийтийн зайлшгүй хэрэгцээнд авах тухай хуулийн төслийг Дэлхийн банкны стандартад нийцүүлэн боловсруулсан боловч энэ хууль өнөөг хүртэл батлагдаагүй байна. Хэрэв хууль батлагдвал БОНХМБ-ыг тухайн хуулинд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай.

Соёлын биет өвтэй холбоотой хуулиуд. Холбогдох хуулиудад Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Соёлын өвийн тухай хуулиуд хамаарна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд газар нутгийн ангиллаараа ялгаатай, газарзүйн байрлалын хувьд өөр өөр бүсэд орших улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөгдсөн, хориглосон үйл ажиллагаа болон газар ашиглах зөвшөөрөл олгоход засгийн газрын олон шатлалын байгууллага, албан тушаалтны үүрэг, хариуцлагыг тусгасан байдаг. Соёлын өвийн тухай хууль нь соёлын биет өвийг бүртгэх, хамгаалах үүрэг, хариуцлагыг тодорхойлно. Төсөл нь соёлын биет өвийг тодорхойлох, бүртгэх, хамгаалах чиглэлээр оролцогч талуудыг дэмжих ёстой.

Үндэстний цөөнхтэй холбоотой хуулиуд: Монгол Улсын Үндсэн хуульд “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан. Гэсэн хэдий ч үндэстний цөөнхийн талаар баримтлах бусад тодорхой хууль тогтоомж байхгүй. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл бөгөөд үндэстний боловсрол, хэлний бодлогоор монгол хэлийг сурталчлах хандлагатай байдаг. Төсөл нь нутгийн уугуул иргэд, үндэстний цөөнхийн бүлгийг төслийн үйл ажиллагааны талаар үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах замаар; тэдгээр хүмүүсийн соёл, амьдралын хэв маягт байдалд тохирсон төслийн үр ашиг / үйлчилгээнд боломжийн хэрээр хамруулж төслийн ашиг тусыг хүртээхдээ ялгаатай харилцааны хэлийг нь ашиглах замаар; малын эрүүл мэндийн үйлчилгээ, олон нийтийн мэдээллийг ил тод болгох, санал хүсэлтийн эргэх холбоо гэх мэт төслүүдийн хэрэгжилтийг мэдээлэх, удирдан чиглүүлэх замаар тус тус төслийн үйл ажиллагаанд хамруулна.

Хөдөлмөрийн нөхцөл ба ХАБЭА: Монгол Улсын Хөдөлмөрийн хууль (1999), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2015) нь ОУХБ-ын хөдөлмөрийн нэгдсэн стандартыг хэрэгжүүлж, ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах эрх, үүрэг хариуцлагыг тогтоодог. Үндэстний хууль тогтоомж нь бүх ажил олгогчдод үйлчилдэг боловч хөдөлмөрийн болон ХАБЭА-н шаардлагуудыг Туслан гүйцэтгэгч бас хангах ёстой гэдгийг шаардах хууль ёсны үүрэг байхгүй. ХАБЭА-тай холбоотой эрсдлийг бууруулах тодорхой арга хэмжээг үндэстний хууль тогтоомжид

тусгаагүй боловч зарим нь үндэсний стандарт, журамд тусгагдсан байна. Иймд БОХНМБ нь туслан гүйцэтгэгчидийг ижил хөдөлмөрийн болон ХАБЭА-н шаардлагыг хангаж, дэд төслийн БОМТ-ний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулан мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулахыг шаардаж болно.

5. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

5.1 Байгаль орчны суурь мэдээлэл

Монгол орны газрын гадаргуу далайн түвшнээс дээш 914-1524 м өндөрт өргөгдсөн, баруун болон хойд хэсэгтээ уул нуруудтай, тэгш өндөрлөгөөс бүрдэх бөгөөд дундаж өндөр нь далайн түвшнээс дээш 1580 метр. Монголын баруун, баруун өмнөд бүс нутгаар Алтайн нурууд сунаж тогтсон, нутгийн баруун хязгаарт хамгийн өндөр цэг болох Алтайн нурууны ноён оргил Хүйтэн (4,375 метр) сүндэрлэнэ. Зүүн ба өмнөд хэсгээрээ нам уулс, цав толгод бүхий тал хээрээс бүрдэнэ. Газрын төрх байдлын хэлбэрүүдэд Азийн хамгийн том цэнгэг нууруудын нэг Хөвсгөл нуур, олон тооны давст нуур, намгархаг, элсэн манхан, өвсөрхөг тал, уулын ой, мөнх цаст уул, мөсөн голууд бий. Монгол орны хойд ба баруун хэсэг нь газар хөдлөлтийн идэвхитэй бүсэд орших тул халуун рашаанууд, унтарсан галт уул элбэг.

Уур амьсгал. Монгол орны газар нутаг нь гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, хойд ба баруун талаараа өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөрт өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Жилийн дундаж температур нь 2°C (45° өргөрөгт)-аас бага, нутгийн баруун хойд хэсгээр -4°C-аас хүйтэн байдаг бол говийн өмнөд хэсэгт 6°C-аас дулаан байна. Өвлийн улирлын дундаж температур -8°C аас -32°C, зуны улирлынх 6°C аас 24°C хооронд хэлбэлздэг. Жилийн нийт хур тунадасны хэмжээ өмнөд говьд 50 мм, хойд хэсэгт 450 мм орчим орж хэлбэлзэнэ. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ хойд болон баруун нутгаар 300-400 мм, Алтайн болон төвийн, хойд ойт хээрийн бүсэд 250-300 мм, зүүн ба тал хээрийн бүсэд 150-200 мм орчим байдаг. Потенциал ууршилт нь нутгийн ихэнхи хэсгээр 500 мм-ээс дээш байна.

Ургамалжилт. Монгол орны ургамалжилтын өвөрмөц байдлаар нь нутгийн хойд хэсгээс өмнөд хэсгийг дагуулан дараах экологийн таван бүсэд ангилдаг: өндөр уулын, ойт хээрийн, тал хээрийн, цөлөрхөг хээрийн болон цөлийн бүс. Ойн мод нийт газар нутгийн 9.2 хувийг эзэлдэг бөгөөд ихэнхидээ нутгийн хойд хэсэгт тайга, ойт хээрийн бүсэд байдаг. Ойт хээр, хээрийн бүс нь нийт газар нутгийн талаас илүү хувийг эзэлдэг (30 хувь ба 20 хувь) бөгөөд эдгээр бүсэд хүн, мал ихээр суурьшиж төвлөрдөг нь биомассын бүтээмж харьцангуй өндөр (600-1800 кг/га) байгаатай холбоотой. Цөлөрхөг хээр, цөлийн бүс нь нийт газар нутгийн 37 орчим хувийг эзэлдэг ба ургамлын гарц багатай (30-400 кг/га) бүс нутагт тооцогддог.

Экосистем ба биологийн олон янз байдал: Монгол Улс нь ОХУ, БНХАУ-ын хооронд, Төв Азийн төв хэсэгт, Сибирийн тайга, Евразийн тал, Төв Азийн говь цөлийн болон Арктикийн байгалийн бүс бүслүүрийн дамжсан хэсэгт байрладаг. Номхон далай, Төв Азийн дотоод ус цуглуулах сав газар, Сибирийн тайга, Төв Азийн тал нутаг, говь цөлийн экосистем нь өвөрмөц зүйлийн амьтан ургамлын төрөл зүйлээр элбэг байдаг нь даян дэлхийн ач холбогдолтой юм. Монголын байгаль экосистем нь дэлхийн болон олон улсын чухал ач холбогдолтой биологийн олон янз байдлыг хамруулдаг бөгөөд үүнд ДБХС-аас тодорхойлсон Даян Дэлхийн тэргүүлэх 35 эко-бүсийн хэсэг (Дорнод Монгол дахь Амур-Хейлун, Баруун Монгол дахь Алтай-Саян), ЮНЕСКО-гийн Дэлхийн байгалийн өвийн 2 газар, Рамсарын конвенцид хамрагдсан 11 газар, шувуудын амьдрах нэн чухал 70 бүс (ОУХХ), Зэрлэг адуу-Тахь (*Equus ferus przewalskii*), Зэрлэг тэмээ (*Camelus ferus*), Азийн зэрлэг илжиг-Хулан (*Equus hemionus*), Говийн баавгай/Мазаалай (*Ursus arctos gobiensis*) зэрэг дэлхийд

ховордсон хөхтөн амьтдын нутаг, Бөхөн (*Saiga tatarica mongolica*) болон бусад ховор ховордсон амьтны нутаг болдог.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь Монгол улсын нутаг дэвсгэрийн 17.4% (27.2 сая га талбай бүхий)-ийг хамруулсан 99 тусгай хамгаалалттай газар нутгаас бүрдэнэ. Үүнээс гадна Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 10.4 хувийг буюу 16.3 га газар нутгийг хамарсан орон нутгийн тусгай хамгаалалттай 911 газар нутаг байна.

Соёлын биет өв/Соёлын дурсгалт газрууд: Монгол Улс соёлын биет өвөөр баялаг. Монгол Улсын хэмжээний соёлын чухал өв, соёлын дурсгалт газруудын жагсаалтыг 1994, 1998, 2008 онд шинэчлэн тогтоож жагсаалт гарган баталсан. Энэхүү жагсаалтад нийт 460 соёлын биет өв бүртгэгдсэн бөгөөд үүнээс 175 нь улсын хамгаалалтад, 285 нь аймгийн хамгаалалтад байдаг.

Агаарын чанар нь Монгол улсын томоохон хотууд, аймгийн төвүүдийн байгаль орчны тулгамдсан асуудал болдог. Агаарын бохирдлын анхдагч эх үүсвэрүүдэд дулааны цахилгаан станцуудууд, жижиг ба дунд оврын халаалтын зуух, уламжлалт халаалт бүхий гэр, байшин, 400 000 гаруй автомашин багтана. Газарзүйн байрлал болон байгаль, цаг уурын эрс тэс нөхцөл байдал нь хүрээлэн буй орчны, ялангуяа Улаанбаатар хот орчмын агаарын чанарын төлөв байдалд сөргөөр нөлөөлдөг. Үүний үр дүнд хүрээлэн буй орчныг бохирдуулагч бодисын агууламж нь олон хоногийн турш хадгалагдаж, Монгол болон олон улсын агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн хэвээр байсаар байна. Хот суурин газрын гэр хорооллуудад түүхий нүүрс, модыг их хэмжээгээр хэрэглэсээр байгаа нь агаарын бохирдлын гол эх үүсвэр болж байгаа төдийгүй энэ нь орчны агаарын чанар, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Эрчим хүч. Өвлийн улиралд Улаанбаатар хотын гурван том дулааны цахилгаан станц цаг тутам агаарт 4.5 сая шоо метр хийн бохирдуулагч, 4.14 тонн тоосонцор, 6.76 кг нүүрстөрөгчийн дутуу исэл агаарт цацдаг. 250 гаруй уурын зуух жилдээ 400,000 гаруй тонн нүүрс түлдэг. Уламжлалт халаалттай гэр, байшин (хотын хүн амын 48% амьдардаг) бүхий гэр хороололд жилд 200 000 тонн нүүрс, 160,000 шоо метр түлшний мод хэрэглэж байна. Хүйтний улиралд агаарт байх нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 2-4 дахин их байна.

Тээврийн хэрэгсэл нь хот, хөдөөгийн агаарын бохирдлын гол эх үүсвэр юм. Томоохон хот, суурин газруудад автомашины тоо богино хугацаанд огцом өссөн.

Усны хомсдол ба бохирдол. Усны хомсдол нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг болон экологийн томоохон асуудлын нэг болж байна. Монгол орны хойд хэсэгт гадаргын усны нөөцийн үндсэн эх үүсвэр болох гол мөрөн нүүр элбэг боловч төвийн, өмнөд хэсэгт болон хот суурин газар, ялангуяа Улаанбаатар хотод үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимтэй хөгжиж ус хангамжид зөвхөн газрын доорхи усны эх үүсвэрийг ашиглаж байгаа нь байгаль орчин, эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлэхэд ноцтой саад учруулж байна. Улсын хэмжээнд бэлчээрийн усан хангамж, ус ашиглалтад анхаарал бага хандуулж байна. 1960-аас 1990 оны хооронд бэлчээрийн ус хангамж сайжирч нийт бэлчээрийн 60 гаруй хувийг усаар хангаж олон худаг гаргасан боловч одоогийн байдлаар тэдгээр 48000 хүдгийн дөнгөж 40 хувь нь л ажиллаж байна. Социализмын үед өрөмдөж гаргасан ихэнх хүдгүүд эвдэрч ажиллагаагүй болсон. Арьс шир боловсруулах үйлдвэр, ахуйн хог хаягдал, бохир ус зайлуулах шугам зэргээс үүдэн хүн ам, үйлдвэрлэл төвлөрсөн газруудын ойролцоох гол мөрөн, ялангуяа Туул, Ерөө, Сэлэнгэ, орхон голуудын бохирдол ихсэж байна.

Газрын доройтол Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга өөрчлөгдсөн, газар тариалангийн үйлдвэрлэл хэт ихэссэн, байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглах, уур амьсгалын өөрчлөлттэй хавсран экосистемд үзүүлэх болон бусад дарамтууд нь байгалийн төрөл зүйлийн амьдрах орчин доройтуулах, тархац хүрээг хумьж ан амьтдын тоо цөөрөхөд хүргэж байна. Монгол Улсад тулгарч буй газрын доройтлын шалтгааныг хүний үйл ажиллагааны болон байгалийн гэж хоёр ангилж үздэг. Байгалийн шалтгаанд 2-3 жилийн давтамжтай болж байгаа ган, байгалийн хуурайшилт, хөрсний чийгийн хомсдол, хавар, намрын хүчтэй салхи, шороон шуурганд хөрсний үржил шимтэй

нимгэн давхарга хийсч хөрсний найрлага өөрчлөгдөх зэрэг орно. Хүний хүчин зүйлээс үүдсэн шалтгаанд уул уурхайн үйлдвэрлэл ба газар тариалангийн хурдацтай хөгжил, уламжлалт мал аж ахуйн өөрчлөлт, бэлчээрийн даац хэтрүүлэх, ялангуяа суурин газар болон худаг, усны цэгүүдийн ойролцоо газруудад үүсдэг талхлалын үр дагавар орно. Монгол улсын мал аж ахуйн салбар нь хөгжлийн сонголт хийх үе дээр ирээд байна. Малын тоо толгойг хянах бодлого, зах зээлийн эдийн засагт суурилсан механизм байхгүй, мөн бэлчээрийн доройтлын талаар мэдлэг мэдээлэлгүй байгаа явдал нь сүргийн тоо толгойг замбараагүй өсгөхөд хүргэж байна. Малын тоо толгойг бэлчээрийн даацаас хэтрүүлснээр бэлчээр доройтож улмаар малын тэжээлийн хомсдол үүсгэнэ.

Хатуу хог хаягдлын хор үршиг. Монголд хатуу хог хаягдлыг хот, суурин газар, сумын төвийн ойролцоо задгай агаарт хаягддаг. Эдгээр хог хаягдал хаа сайгүй тархаж, хөрсний бохирдолд ихээр нөлөөлдөг учир анхааралдаа авах нь зүйтэй. Ялангуяа Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад хот тэлэлт ба хот төлөвлөлт хоёрын хооронд маш том ялгаа байна. Монгол улсад хог хаягдлыг цэвэрлэх, дахин боловсруулах чанарын шаардлага хангасан байгууламж байхгүй. Тиймээс хог хаягдлыг хот суурин газарт хаягддаг. Ялангуяа Улаанбаатар хот хог хаягдлын асуудлыг шийдвэрлэхэд нэлээд бэрхшээлтэй тулгарч байна.

Хөрсний бохирдол Монгол улсад хөрсний бохирдол нь автомашины хаягдал тосыг цэвэршүүлэх болон уул уурхайн олборлох үйл явц, хөдөө аж ахуй үйлдвэрлэлд бордоо ашиглах гэх мэт үйлдлүүдээс хаягдал химийн бодисын их хэмжээгээр гадагшилж хөрсөнд шингэх замаар үүсдэг. Нүүрсний хэрэглээ нь агаарын бохирдлын хамгийн том хүчин зүйл болохын зэрэгцээ нүүрс зөөх, газарт үнс асгах зэргээс болж хөрс бохирдож байна.

5.2. Нийгмийн суурь мэдээлэл

Хүн ам. 2019 оны байдлаар Монгол Улсын хүн амын тоо 3 296 866, өслт нь дунджаар 1.9%, дэлхийн хамгийн цөөн хүн амтай орны тоонд ордог. Нийт хүн амын 67.5% орчим хувь (2 146 716 хүн) хотод амьдардаг бөгөөд үүний 68 орчим хувь (1 462 973 хүн) нь нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг. Хөдөө орон нутагт хүн амын нягтрал нэг км квадрат тутамд 0.5 хүн амьдардаг бөгөөд энэ нь улс даяар орон нутагт бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн амьжиргаа түлхүү эзэлж байгааг харуулж байна.

Уугуул иргэд, ястан, үндэстний цөөнх бүлэг. Монгол улсын үндсэн хүн ам нь монголчууд бөгөөд тархай бутархай суурьшсан ард түмэн. Хүн амын 85 орчим хувь нь Монгол гаралтай халх буюу нутгийн уугуул иргэд байдаг хэдий ч үндэстний цөөнх болох (4 хувь орчим) казах хэлээр ярьдаг мусульман шашинтай Казак үндэстэн нь ихэвчлэн Баян-Өлгий аймгийн баруун хойд хэсэгт амьдардаг. 1840 онд одоогийн Баруун Хятадын нутгаас Казах овгууд Монгол улсад цагаачлах хүсэлт тавьснаар тэдний шилжилт хөдөлгөөн эхэлсэн хэмээн баримт бичигт үлджээ. Баримт бичигт дурдсанаар 1905 онд 1370 казах өрх байсан бол 1924 онд (Монгол улс социализмын замд орсон жил) энэ тоо 1870 өрх болж өссөн байна. 1989 он гэхэд Казахуудын тоо ойролцоогоор 120,000 хүн ам болж өссөн. 2020 оны 9-р сарын байдлаар Монгол Улс ОУХБ-ын Нутгийн уугуул, омгийн хүмүүсийн тухай 169 дүгээр Конвенцид нэгдээгүй хэвээр байна. Уг төсөл 4 аймгийн 8 суманд хэрэгжих ба 7 сумын нутагт Халх хүмүүс, Ховд аймгийн Мөст суманд Захчин хүмүүс байна.

Жендэр: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн оргил жил болох 2011 онд Жендэрийн Эрх Тэгш Байдлыг Дэмжих тухай хууль батлагдаж, хуулийн 5 дугаар зүйлд жендэрийн тэгш байдлын зарчмыг “эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн болон бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцлийг хангах эрхтэй” гэж тодорхойлсон байдаг. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан эдийн засгийн оролцоо, боломжийн жендэрийн ялгааны үзүүлэлтээр Монгол улс 2006 онд 0.704 оноогоор 21-р байранд орж байсан бол 2018 онд 0.780 оноогоор 20-р байранд орж ахисан байна.

Ядуурал. Монгол улсын Үндэсний Статистикийн хороо, Дэлхийн банктай хамтарсан судалгаагаар хүн амын хэрэглээ ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлдэг ядуурлын гүнзгийрэлт 2018 онд 7,2 хувь гэж үнэлсэн. Ядуучуудын тэгш бус байдлын зэргийг хэмждэг ядуурлын мэдрэмж 2018 онд 2.7 хувь болж буурсан. Хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл нэмэгдэж байна. Хөдөө орон нутагт 2016-аас 2018 оны хооронд ядуурал 4.1 пунктээр буурсан бол хотод 0.1 пунктээр нэмэгдсэн. Хөдөө орон нутагт ядуурлын түвшин өндөр хэвээр байгаа боловч Монгол улсын нийт хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдарч байгаагаас ядуурал хот суурин газарт нэмэгдэж байна. 2018 оны судалгаагаар, Монгол улсын хүн амын 28.4 хувь нь ядуурлын түвшингээс доогуур түвшинд байна.

Боловсрол. Монгол Улсын боловсролын систем нь ясли, цэцэрлэг, бага сургууль, дунд сургууль, их сургууль гэх дарааллаас бүрдэнэ. Сум болгонд дор хаяж нэг ясли, нэг цэцэрлэг байдгаас гадна хувийн барилга байгууламжтай хувийн цэцэрлэг байдаг (3-аас дээш насны хүүхдүүдэд зориулагдсан). Сумын төв бүр алслагдсан малчин өрхүүдийн хүүхдүүд байрладаг дотуур байртай. Сумын төв бүр алслагдсан малчин айлын хүүхдүүдийг байрлуулах дотуур байртай. Бага, дунд сургуулийн боловсрол нь 10 жил байсан боловч 11 жил хүртэл сунгагдсанаас үргэлжлэн 2008-2009 оны хичээлийн жилд 12 жилийн тогтолцоо руу шилжсэн. Монголд хичээлийн жил есдүгээр сараас эхэлж ерөнхий боловсролын сургууль төгсөх хүсэлтэй хүүхдүүд ихэвчлэн аймгийн төвүүдийн сургуульд суралцаж төгсөх шаардлагатай болдог. Ер нь хөдөө орон нутгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс 8-р анги хүртэл сургуульд сурч, уншиж, бичиж сурсан болно. Охид, хөвгүүд барилга, мэргэжлийн боловсрол болон төрийн бусад үйлчилгээнд тэгш хамрагдах боломжтой.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. 1990-ээд оны дунд үед эрүүл мэндийн салбарт хийгдсэн шинэчлэлт нь анхан шатны тусламж үйлчилгээ, өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахад чиглэгдсэн. Энэ нь эдийн засаг хөгжихийн хэрээр сүүлийн 15 жилийн хугацаанд тасралтгүй хөгжиж эрүүл мэндийн нөхцөл байдал сайжрахад нөлөөлсөн. Эрүүл мэндийн хүрээнд жендэрийн хамгийн чухал асуудал бол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын хоорондын зөрүү юм. Дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4.3 жилээр урт насалдаг бол 1992 онд манай улсад энэ үзүүлэлт 4.19 жил байсан бол 2018 онд 9.67 жил болсон байна. 1995-1998 онуудад эрэгтэйчүүдийн дундаж наслалт нь гэнэт буурсан нь, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэний сөрөг үр дагавартай холбоотой. Гэсэн хэдий ч 2000 оноос хойш дундаж наслалт тогтмол өссөн үзүүлэлттэй байгаа боловч жендэрийн тэгш бус байдал нэмэгдэж байна (Азийн Хөгжлийн Банк, 2018 он). Нас баралтын тэргүүлэх шалтгаан нь халдварт бус өвчин (зүрх судасны өвчин, хавдар) болон гадна шалтгаанууд (гэмтэл, хордлого) юм. Амьсгалын болон хоол боловсруулах тогтолцооны өвчин нь өвчлөлийн гол шалтгаан бөгөөд хот суурин газар гадны нөлөө (гэмтэл, хордлого), хөдөөгийн нутагт шээсний замын өвчин зэргээс шалтгаалж байна. Эрүүл мэндийн тогтолцоо нь аймгийн хэмжээнд төвлөрсөн бус байдлаар явагддаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дийлэнх хувийг төрийн үйлчилгээ үзүүлдэг.

Мал аж ахуйн болон ноолуурын үйлдвэрлэл. Монголын хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн салбар нь нийт ажиллах хүчний 30%, уул уурхайн салбартай харьцуулахад дотоодын нийт бүтээгдэхүүний 12,2% (2016)-ийг бүрдүүлж байна. Хүнсний үйлдвэрлэлийн салбар (мах боловсруулах, сүү, сүүн бүтээгдэхүүн болон ундаа) болон нэхмэлийн үйлдвэрлэлийн салбар (ноос болон ноолуур) гэх хоёр салбар нь үйлдвэрлэлийн салбар дахь нийт үйлдвэрлэлийн 52% (2016)-ийг бүрдүүлж байна. 2016 оны хийсэн мал тооллогоор 27,9 сая толгой хонь, 25,6 сая толгой ямаа, 4,1 сая толгой үхэр, 3,6 сая толгой адуу болон 400 мянган толгой тэмээ тус тус бүртгэгдсэн байна. Түүний өмнөх жил буюу 2015 онд мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 448 мян.тн мах, 874 мян.тн сүү, 8,900 тн ноолуур болон 448 мян.тн ноос тус тус байсан байна. 2017 онд ноолуурын

салбар ойролцоогоор 7,000 тн түүхий ноолуур, 7,000 тн угаасан ноолуур (85% экспортонд гаргасан), 1,050 тн хагас боловсруулсан ноолуур, 620 тн ээрсэн утас, 434 тн нэхмэл хувцас болон 186 тн сүлжмэл хувцас тус тус үйлдвэрлэсэн. Газар тариалан болон мал аж ахуй нь төрөл бүрийн байгалийн нөөцийн эх үүсвэрээс хамаарах ба бүс нутгийн ялгаатай байдал нь үйлдвэрлэлийн хэмжээнд шууд нөлөөлж байна. Цаг агаарын өөрчлөлт, эрс тэс уур амьсгал, хахир өвөл, зуд эсвэл цасан шуурга болон бусад байнгын цаг агаарын тогтворгүй өөрчлөлтүүд нь тодорхой сөрөг үр дагавар үзүүлдэг төдийгүй цаашид түүхий эд материалын бэлтгэн нийлүүлэлт хэлбэлзэхэд хүргэдэг. Иймд хөдөө аж ахуй болон мал аж ахуйн хөгжлийг үндэсний хэмжээнд авч үзэх хэрэгтэй байна.

6. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭ

6.1 Байгаль орчны болзошгүй нөлөөлөл

Энэхүү төслийн хүрээнд цахимжуулах үйл ажиллагааг санал болгож байгаагаас хамааран төслийн зорилтот газруудын байгаль орчинд ноцтой хохирол учруулахгүй. Гэсэн хэдий ч төслийн Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд малчдын хоршоо нь саравч, хашаа, мал угаах зөөврийн банн зэрэг бага хэмжээний үр өгөөжтэй дэд бүтцийг барихад туслалцаа авч болох бөгөөд энэ нь газрын хөрсөнд бага хэмжээний байгаль орчны сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Малын саравч засварлах, мал угаах зөөврийн банн эсвэл хашааг суурилуулах зэрэг барилгын засварын ажлууд нь байгаль орчинд дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

- Тоосжилт үүсэх
- Дуу чимээ
- Бохир ус, хатуу хог хаягдал үүсгэх
- Орон нутгийн замын хөдөлгөөнд саад учруулах

Тохиолдож болзошгүй эдгээр нөлөөллүүд нь бага хэмжээний, түр зуурын, орон нутгийн шинжтэй бөгөөд Хавсралт 2-т заасан барилгын ажлын сайн туршлагыг нэвтрүүлсэнээр нөлөөллийг багасгах боломжтой. Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөлөл, түүнийг багасгах арга хэмжээг дараах хүснэгтэд харуулсан болно.

Хүснэгт 4 Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Төслийн үе шат	Байгаль орчны болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
Барилгын үе шат	<ul style="list-style-type: none"> • Дуу чимээ гаргах • Тоосжилт үүсгэх • Хатуу хог хаягдал нэмэгдэх (хатуу болон барилгын хог, нураасан барилгын материал, хоосон сав) • Замын хөдөлгөөнд саад учруулах 	<ul style="list-style-type: none"> • Тухайн нутгийн оршин суугчдын өдөр тутмын амьдралд саад учруулахгүй байхын тулд тэдэнтэй зөвлөлдөж барилгын ажлын төлөвлөлтийг хийж гүйцэтгэнэ. • Жижиг барилгын ажлыг зөвхөн өдрийн цагаар хийж гүйцэтгэх. • Дуу чимээний бохирдлоос сэргийлж автомашины хурдны хязгаар тогтоох • Оршин суугчид төвлөрсөн газруудаар төслийн тээвэрлэлтийг дамжин өнгөрүүлэхээс зайлсхийх эсвэл багасгах

		<ul style="list-style-type: none"> • Барилгын материалыг бэлтгэхэд үүсэх тоосжилтыг багасгах, түүнийг дарах аргыг хэрэглэх • Үйл ажиллагаа болон ашиглалтын шилдэг туршлагыг ашиглах • Барилгын ажлын талбай бүрд хогийг ангилан ялгадаг байх • Хог хаягдлыг барилгын талбайгаас болон бусад газраар тээвэрлэхдээ ажилчид, орон нутгийн иргэдэд хор хөнөөл учруулахаас зайлсхийх ба түүнийг багасгах • Бага хэмжээний барилгын ажлын үед ч явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах үүднээс замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээг тавина.
Ашиглалтын үе шат	<ul style="list-style-type: none"> • Бохир ус хуримтлагдах • Тоосжилт үүсэх • Хатуу хог хаягдал нэмэгдэх • Мал угаах баннанд химийн бодис хэрэглэснээс үүсэх ус болон хөрсний бохирдол • Цахилгаан эрчим хүчний хэт их хэрэглээ • Усны хэт их хэрэглээ • Ноолуурын үйлдвэрлэлээс шалтгаалан ямааны тоо толгой өссөнөөс үүдсэн бэлчээрийн доройтол 	<ul style="list-style-type: none"> • Төслийн БОНХМБ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх • Оролцогч талуудыг чиглүүлэх болон тэднийг сургалтанд хамруулах • Хог хаягдлын менежмент гэх мэт нөлөөллийг багасгах арга хэмжээг тусгасан дэд төслийн БОМТ боловсруулж хэрэгжүүлэх • Байгаль орчинд ээлтэй туршлагыг нэвтрүүлнэ. • Барилгын материалыг бэлтгэхэд үүсэх тоосжилтыг багасгах, түүнийг дарах аргыг хэрэглэх • Эрчим хүчний хэрэглээг тогтмол хянах, түүнийг хэмнэлттэй ашиглах талаархи сургалтыг зохион байгуулах • Усны хэрэглээг тогтмол хянаж тэмдэглэх • Сантехникийн засварын ажлыг тогтмол гүйцэтгэх ба ус алдсан тохиолдолд түүнийг олж засах • Бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн талаархи зөвлөмж, гарын авлагыг боловсруулж малчид болон бусад оролцогч талуудад тараах

6.2 Нийгмийн болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Төслийн хүрээнд шинэлэг дижитал шийдлийг ашигласнаар нийгэмд эерэг үр нөлөө үзүүлнэ төсөөлж байна. Үүгээр зогсохгүй малчид, бусад оролцогчид, зах зээл болон үйлчилгээний харилцаа холбоог сайжруулахаас гадна мал аж ахуйн бүтээгдэхүүн, ялангуяа ноос ноолуураас авах өрхийн орлого нэмэгдэх боломжтой. Төслийн хүрээнд айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, орлогын алдагдал бий болгохгүй ба үндэсний цөөнхөд аливаа сөрөг нөлөө үзүүлэхгүй. Тухайн орон нутагт үндэсний цөөнхи байгаа тохиолдолд олон нийтийн хэлэлцүүлгийг тохиромжтой хэлбэрээр зохион байгуулна.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан тайлангаас харахад хөдөө орон нутагт хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд орон нутгийн малчид, тариаланчдад зориулсан чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа, сургалтыг эрчимтэй зохион байгуулж байгаа явдал нь тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэнд эерэг нөлөө үзүүлж байна. Бага хэмжээний барилга/байгууламжийг барихад ажил эрхлээгүй, мэргэжилгүй (эрэгтэй, эмэгтэй) зарим иргэдийг ажиллуулж байгаа нь тухайн орон нутгийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. Энэ хугацаанд орон нутагт ажил эрхлэх нь нийгэм, эдийн засгийн стандартыг нэмэгдүүлэх болно. Төсөл нь археологи, түүх, эсвэл соёлын чухал ач холбогдол бүхий газар, талбайг хөндөхгүй бөгөөд төслийн зорилтот аймгуудад байгаа Улсын болон Аймгийн хамгаалалтад авсан хүлээн зөвшөөрөгдсөн буюу бүртгэгдсэн үндэсний/аймгийн соёлын өв, шашны дурсгалт газрууд ч хамаарна. Барилгын болон ашиглалтын үе шатанд төслийн нийгмийн болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг Хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт 5 Төслийн нийгмийн нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ

Төслийн үе шат	Нийгмийн болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
Барилгын үе шат	<ul style="list-style-type: none"> • Халтирах ба унах • Өндөрт гарч ажиллах • Хөдөлгөөнт машин механизм Хөдөөгийн сумын замын хөдөлгөөнийг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Барилгын талбай дахь ашиглагдахгүй байгаа материалыг тусгай бэлтгэсэн талбайд ангилж байрлуулах замаар хадгалалтын сайн туршлагыг нэвтрүүлнэ. • Ажилтныг оосортой хамгаалалтын бүс гэх мэт өндрөөс унахаас сэргийлэх хамгаалалтын системийг ашиглахад сургаж түүнийг байнга хэрэглүүлэх • Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, машин механизмын ажлын орчин, болон явган хүний зам зэргийг төлөвлөж тусгаарлах • Барилгын ажлын үед явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах үүднээс замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээг тавина.
Ашиглалтын үе шат	<ul style="list-style-type: none"> • Цахим болон жирийн хоршоонд элссэн өрхүүдийн хоорондын зөрчил • Хөдөөгийн сумын замын хөдөлгөөнийг нэмэгдүүлэх • Орон нутагт ажиллах хүч авах боломж нэмэгдэх • Эмзэг бүлгийн хүмүүсийг төслийн үйл ажиллагаанд хамруулахгүй байх 	<ul style="list-style-type: none"> • Төслийн БОНХМБ ялангуяа ОТХЗТ болон ХХЗЖ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх • Оролцогч талуудыг чиглүүлэх болон тэднийг сургалтанд хамруулах

6.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учруулах аюул, түүнийг бууруулах арга хэмжээ

ОУСБ болон ДБ-ны Байгаль Орчин, Эрүүл Мэнд Аюулгүйн Байдал (БОЭМАБ)-ын удирдамж нь Олон Улсын Аж Үйлдвэрийн Сайн Түршлага (ОУАҮСТ)-ийн ерөнхий болон салбарын тодорхой жишээнүүд бүхий техникийн зөвлөмж баримт бичиг юм. “Малчдын Цахим Хоршоо” төслийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хүрээнд Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, Мал аж ахуйн үйлдвэрлэл, Нэхмэл эдлэлийн үйлдвэрлэлийн Байгаль Орчин, Эрүүл Мэнд Аюулгүйн Байдлын Удирдамжийг ашиглана. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд төслийн оролцогч талуудад шаардлагатай сургалтыг хийнэ. Түүнчлэн төслийн зүгээс дэд төслийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шалгалт хийнэ. Эдгээр үйлдвэрлэлийн салбарын БОЭМАБ-ын удирдамжууд нь БОЭМАБ-ын ерөнхий удирдамжийн баримт бичигтэй хамт ашиглахаар боловсруулсан бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн бүхий л салбарт хамаарах БОЭМАБ-ын нийтлэг асуудлуудын талаар зааварчилгаа өгдөг.

Хүснэгт 6 Хөдөлмөрийн Аюулгүй байдал, Эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээ

Үйлдвэрлэлийн салбарууд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учрах аюул	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтын арга хэмжээ
Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах	Биет аюул	<p>Явах болон ажиллаж буй гадаргууг цэвэр, хуурай байлгах, ажилчдыг халтирдаггүй гутлаар хангах;</p> <p>Ажилчдад зориулсан тоног төхөөрөмж (үүнд машин механизмын аюулгүйн хэрэгслийг зохистой хэрэглэх), дуу намсгах чихний хамгаалалт гэх мэт Хувийн хамгаалалтын хэрэгслээр (ХХХ) хангаж, тэдгээрийн зөв зохистой хэрэглээний талаар сургалтыг зохион байгуулах;</p> <p>Үйл ажиллагаануудыг хоорондоо давхардуулж зөрчилдөхгүй байхаар зохион байгуулж, мөргөлдөх, унахгүй байх нөхцлийг бүрдүүлэх;</p> <p>Тээврийн коридор, ажлын талбайн хил хязгаарыг тогтоож, тавцан, шатанд бариулыг зохих ёсны дагуу байрлуулах;</p> <p>Чийгтэй өрөөн дэх бүх цахилгаан хэрэгсэл, үгсралтыг газардуулах.</p>
	Биологийн аюул	<p>Тоос, аэрозол үүсгэдэг үйл ажиллагаанаас зайлсхийх (жишээлбэл даралттай агаар эсвэл өндөр даралттай усыг цэвэрлэгээнд ашиглах), тоос шороо, аэрозолын нөлөөллийг багасгах, арилгах зорилгоор хаалттай буюу хагас хаалттай бүсийг зохих агааржуулалтаар хангах;</p> <p>Тоос шороо үүсч байгаа хэсэгт шүүлтүүр ба / эсвэл циклоноор тоноглогдсон яндангийн агааржуулалтыг суурилуулах;</p> <p>Ажилчдыг технологийн үйл ажиллагаанд тохирсон ХХХ-ээр хангах;</p>

		<p>Ажилчдын хувийн ариун цэврийг сахихын тулд ажил, ариун цэврийн байгууламжуудыг тусгай газар байрлуулах;</p> <p>Баталгаагүй сүү сүүн бүтээгдэхүүнтэй шууд харьцахаас зайлхийх.</p>
	Химийн бодисын аюул	<p>Аюултай бодисыг бага химийн аюултай бодисоор солих;</p> <p>Химийн аюултай бодисыг ажлын орчинд цацагдахаас зайлсхийх эсвэл бууруулах инженерийн болон зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэнээр өртөлтийн түвшинг олон улсад тогтоосон эсвэл зөвшөөрөгдсөн хэмжээнээс доогуур байлгах;</p> <p>Өртсөн эсвэл өртөж болзошгүй ажилчдын тоог хамгийн бага түвшинд байлгах;</p> <p>Олон улсын химийн аюулгүй байдлын карт (ICSC), Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудас (MSDS) эсвэл түүнтэй адилтгах үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага, стандартын дагуу шошгололт, тэмдэглэгээ хийх замаар ажилчдад химийн аюулын талаар мэдээллэнэ. Аливаа бичгэн харилцаа нь аюулд өртсөн ажилтан боло анхны тусламж үзүүлж буй хүнд ойлгох болон уншихад хялбар хэл дээр бичигдсэн байх;</p> <p>Байгаа мэдээллийг ашиглах (МАБМХ гэх мэт), аюулгүй ажиллагааны дадал, ХХХХ-ийг зөв зохистой ашиглах талаар ажилчдыг сургана.</p>
	Халуун, хүйтэн, цацраг идэвхт өртөх	<p>Сүү боловсруулах үйлдвэрүүдийн ажилчид үйл ажиллагааны явцад халах, хөргөлтийн өрөөнөөс гарах хүйтэнд өртөх боломжтой. Дулаан, хүйтэнд өртөх менежментийн талаархи зөвлөмжийг БОЭМАБ-ын ерөнхий удирдамжид тусгасан болно.</p>
Мал аж ахуйн үйлдвэрлэл	Биет аюулд өртөх	<p>Бүх газар доорх өтөг бууц хадгалах савыг зохих ёсны дагуу булж хангалттай өндөр хашаагаар хаших;</p> <p>Аюултай хий (ж. нь устөрөгчийн сульфид) ялгаруулалтыг багасгахын тулд шингэн бууцийг (ж. нь амбаар, шахах станц, хадгалах сав, хэрэглээний сав) хадгалах;</p> <p>Малын хөдөлгөөнийг хөнгөвчлөх, фермийн ажилчдыг малын хашаа руу орох хэрэгцээг багасгах зорилгоор малын хашаа, хаалга, арматурыг загварчлах;</p> <p>Малаа зөв арчлах талаар ажилтнуудад зааварчилгаа өгөх, хазах, өшиглөх тохиолдлуудыг бууруулах.</p>
	Химийн бодисын аюул	<p>Аюултай бодисыг бага химийн аюултай бодисоор солих;</p> <p>Химийн аюултай бодисыг ажлын орчинд цацагдахаас зайлсхийх эсвэл бууруулах инженерийн болон зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэнээр өртөлтийн түвшинг олон улсад тогтоосон эсвэл зөвшөөрөгдсөн хэмжээнээс доогуур байлгах;</p> <p>Өртсөн эсвэл өртөж болзошгүй ажилчдын тоог хамгийн бага түвшинд байлгах;</p>

		<p>Олон улсын химийн аюулгүй байдлын карт (ICSC), Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудас (MSDS) эсвэл түүнтэй адилтгах үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага, стандартын дагуу шошгололт, тэмдэглэгээ хийх замаар ажилчдад химийн аюулын талаар мэдээллэнэ. Аливаа бичгэн харилцаа нь аюулд өртсөн ажилтан боло анхны тусламж үзүүлж буй хүнд ойлгох болон уншихад хялбар хэл дээр бичигдсэн байх;</p> <p>Байгаа мэдээллийг ашиглах (МАБМХ гэх мэт), аюулгүй ажиллагааны дадал, ХХХХ-ийг зөв зохистой ашиглах талаар ажилчдыг сургана.</p>
	Биологийн бодисд өртөх	<p>Ажилчдад биологийн бодисын хордлогын талаар мэдээлэх, тэдгээр эрсдлийг танин мэдэх, багасгах сургалт зохион байгуулах;</p> <p>Өвчин үүсгэгч организм агуулсан материалд хүрэхээс хамгаалах зорилгоор хувийн хамгаалах хэрэгслээр хангах;</p> <p>Биологийн бодисуудад харшил үүсгэдэг хүмүүст эдгээр бодисуудтай ажиллахгүй байх.</p>
	Хязгаарлагдмал бүс	<p>Хязгаарлагдмал бүс, түүний сөрөг нөлөөг бууруулахын тулд инженерчлэлийн шийдлийг өөрийн боломжид тулгуурлан хэрэгжүүлэх;</p> <p>Хязгаарлагдмал бүсэд зөвшөөрөл олгохдоо агааржуулалт, хяналт, байнгын аюулгүй байдлыг хангаж аврах ажиллагаа зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байхыг шаарддаг. Хязгаарлагдмал зай талбайд нэвтрэхдээ дамжин өнгөрч байгаа өрөө нь аврах ажиллагаа, түргэн тусламжийн үйлчилгээг саадгүй үзүүлэх боломж бололцоог хангасан байх;</p> <p>Хязгаарлагдмал бүсэд нэвтрэх зөвшөөрөлтэй ажилчдын 90% -ийг зориулалтын багаж хэрэгсэл, таарсан хамгаалалтын хувцсаар хангах;</p> <p>Хязгаарлагдмал бүсэд тусгай зөвшөөрлөөр нэвтрүүлэхээс өмнө ажилчдыг тухайн бүсэд тохиолдож болзошгүй аюулыг хянах, агаарын чанарыг туршилтыг хийх, шаардлагатай ХХХ-ийн хэрэглээний талаар зохих сургалтанд бүрэн хамруулах бөгөөд ХХХ-ийг зөв хэрэглэх чадвартай болсон эсэхийг баталгаажуулж шалгана.</p>
Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах	Биет аюул	<p>Ажилчдыг Хувийн Хамгаалалтын Хэрэгсэл (ХХХ) огтлох, төмөр зүсэх ажилд зориулагдсан төмөр бээлий, савхин хормогч, хайчлах багаж гэх мэт хэрэгслээр хангаж зөв зохистой ашиглах сургалт (техникийн аюулгүй байдлыг хангах хэрэгслийг зохих ёсоор ашиглах)-нд хамруулах;</p> <p>Зохих сургалтанд хамрагдаж, мал нядлах зөвшөөрөлтэй хүнээр ёс заншлын дагуу мал нядалгааны ажлыг гүйцэтгүүлэх;</p> <p>Нядалгааны байрны шалыг нойтон үед халтирахаас хамгаалсан</p>

		<p>загвараар барих;</p> <p>Ажилчдыг амьтанд зүй зохистой харьцах арга зүйд сургах, үүнд мал амьтантай харьцах, хорих зориулалттай хэрэгслийг хэрэглэх, тоног төхөөрөмжийг ашиглах;</p> <p>Малыг байгууламж руу тайван шилжүүлэх, ажилчдад зугтах боломж бүхий ослын гарцийг малын хашаа/саравч/малын талбайд барьж байгуулах;</p> <p>Хяналттай орчинд бод малыг цахилгаанаар цохиж (жишээ нь: цахилгаан цохидог хайрцаг) нядлах.</p>
	Биологийн аюул	<p>Тоос, аэрозол үүсгэдэг үйл ажиллагаанаас зайлсхийх (жишээ нь: даралттай агаар эсвэл өндөр даралттай усыг цэвэрлэгээнд ашиглах), тоос шороо, аэрозолын нөлөөллийг багасгах, арилгах зорилгоор хаалттай буюу хагас хаалттай бүсийг зохих агааржуулалтаар хангах;</p> <p>Ажилчдад гэдэс, дотор цэвэрлэх үйл ажиллагаанд тохирсон ХХХ (жишээ нь: хамгаалалтын хувцас, бээлий, маск)-ээр хангах;</p> <p>Ажилчдын хувийн ариун цэврийг сахихын тулд ажил, ариун цэврийн байгууламжуудыг салангид байлгах;</p> <p>Ажилчид хүлээстэй мал, өндөр эрсдэлтэй материалд шууд хүрэхээс зайлхийхийн тулд хүлээстэй мал, өндөр эрсдэлтэй материалыг байлгах талбайг төлөвлөж, бүх хог хаягдлыг өдөр бүр хаях.</p>
	Химийн бодисын аюул	<p>Угаалгын нунтаг, ариутгалын бодисыг ашиглах, хадгалахдаа (БОЭМАБ-ын ерөнхий заавар)-т урьдчилан сэргийлэх арга хэмжээг зааснаар авах. Химийн бодисыг хоол хүнс, ус ундаатай хадгалах, тээвэрлэхгүй байх, цоожтой, тодорхой байрлуулсан газарт хадгалах;</p> <p>Улирлын болон бусад түр хугацаагаар ажиллаж байгаа ажилчдыг бүрэн бэлтгэх хүртэл химийн бодистой ажиллахаас урьдчилан сэргийлэх;</p> <p>Малын хашаа саравчийг халдваргүйжүүлэх үед амны хамгаалалт, хамгаалалтын битүү хувцсыг ашиглах.</p>
	Халуун, хүйтэн, цацраг идэвхт өртөх	<p>Ажилчид дотоод уур амьсгалын хэлбэлзэл, тухайлбал зумлах, хүйхлэх, зүлгэх гэх зэргээс гарах галын дөлөөс үүдэн халалт үүсэх, хөргөгчтэй өрөөнөөс үүдэн хөрөлт зэрэг уур амьсгалын өөрчлөлтөд өртөх боломжтой. Эдгээр аюулыг зохицуулах зөвлөмжийг БОЭМАБ-ын ерөнхий удирдамжаас авах боломжтой.</p>
	Дуу чимээнд өртөх	<p>Ажлын үеэр үүсэх чимээ шуугиан, чичирхийллийн эх үүсвэрүүд нь гахайг цахилгаанаар цохиулах, цахилгаан хөрөө, уур, конденсатор, агааржуулалт, цохилттой тоног төхөөрөмж, агаарын даралт хэмжих хэрэгслээс гарах дуу чимээ орно. Дуу чимээ, чичиргээний аюулыг удирдан зохицуулах зөвлөмжийг БОЭМАБ-ын ерөнхий удирдамжаас авах боломжтой.</p>

Нэхмэлийн үйлдвэрлэл	Химийн бодисын аюул	<p>Ажлын байранд ялангуяа хөвөнгийн үйлдвэрт тоос зайлуулах зорилгоор тоос соруулах, дахин боловсруулж агааржуулах системийг суурилуулах;</p> <p>Шахсан агаараар “шүүрдэх” технологийн оронд гадаргууг соруулж цэвэрлэх аргыг ашиглах;</p> <p>Тогтмол цэвэрлэгээ хийх журмыг ялангуяа “Ноосоор дүүрсэн” хэсэгт хэрэгжүүлэх;</p> <p>Хөвөн болон хөвөнгийн хаягдлыг боловсруулахдаа механик аргыг ашиглах;</p> <p>Өртсөн ажилчид хувийн хамгаалах хувцас хэрэгслийг шаардлагатай тохиолдолд маск, амьсгалын аппарат зэргийг хэрэглэнэ.</p>
	Биет аюул	<p>Ажилчдыг Хувийн Хамгаалалтын Хэрэгсэл (ХХХ) хамгаалалтын чихэвч гэх мэт хэрэгслээр хангаж зөв зохистой ашиглах сургалт (техникийн аюулгүй байдлыг хангах хэрэгслийг зохих ёсоор ашиглах)-нд хамруулах;</p> <p>Үйл ажиллагаануудыг хоорондоо давхардуулж зөрчилдөхгүй байхаар зохион байгуулж мөргөлдөж, унахаас зайлхийх боломжийг бүрдүүлэх;</p> <p>Тээврийн коридор, ажлын талбайн хил хязгаарыг тавьж, тавцан, шатанд бариулыг зохих ёсны дагуу байрлуулах;</p> <p>Чийгтэй өрөөнд байгаа бүх цахилгаан хэрэгсэл, суурилуулалтыг газардуулах.</p>
	Халуун уур	<p>Дулаан, өндөр чийгшилд өртөх ноцтой эрсдэл нь нойтон боловсруулалт хийх, хуурай өнгөлгөөний үйл ажиллагааны явцад тохиолддог бөгөөд энэ нь технологийн үйл ажиллагаанд уур, халуун шингэнийг хэрэглэснээс үүсдэг. Урьдчилан сэргийлэх, хянах зөвлөмжийг БОЭМАБ-ын ерөнхий удирдамжид тусгасан.</p>
	Дуу чимээ	<p>Нэхмэлийн үйлдвэрүүдийн дуу чимээний гол эх үүсвэрүүд нь утас боловсруулах (жишээлбэл, барзгарчлах, мушгих, давхарлах), нэхмэл даавууны үйлдвэрлэлтэй холбоотой. Хувийн чихний хамгаалалтыг ашиглах зэргээр дуу чимээний зохицуулалтын талаар БОЭМАБ-ын ерөнхий удирдамжид тусгасан.</p>
	Ионжуулагч ба ионжуулдаггүй цацраг	<p>Рентген туяа станцыг заримдаа өнгө хувиргалтын тасралтгүй үргэлжилсэн хөөсөн дэх хөөсний зузааныг хэмжих, саван дахь будагчийн түвшинг хянах системд ашигладаг. Эдгээр тоног төхөөрөмжийн операторууд нь БОЭМАБ-ын ерөнхий удирдамжид заасны дагуу өртөлтийн түнг хязгаарлах ионжуулагч цацрагийн хамгаалалтын арга хэмжээг ашиглах замаар хамгаалагдсан байх ёстой.</p>

6.4 Мал амьтны амьдрах нөхцлийг сайжруулах арга хэмжээ

Төслийн хүрээнд мал аж ахуйн арилжааг хийх үед мал амьтны амьдрах нөхцөл нь чухалд тооцогдоно. Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, мал аж ахуй эрхэлдэг байгууллагууд, малчид болон төслийн бусад оролцогч талууд мал амьтны амьдрах нөхцлийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийн эргэх сүлжээн дэх хэсгүүдэд тусгах ёстой хэдий ч хэрэглэгчид хүнсний аюулгүй байдал, мал амьтны амьдрах таатай нөхцөлийн өндөр стандартыг шаардсаар байна.

Тийм учраас, ХХААХҮЯ болон түүний ТХН нь ОУСК-ын удирдамжийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн малын амьдрах нөхцлийн туршлагыг нэвтрүүлнэ (https://www.ifc.org/wps/wcm/connect/topics_ext_content/ifc_external_corporate_site/sustainability-at-ifc/publications/publications_gpn_animalwelfare_2014). Дэд төсөлд хамрагдагчид мөн эдгээр шаардлага, нөхцлийг төслийн загварт тусгаж, мөрдөн ажиллана. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс холбогдох сургалтыг дэд төсөл хэрэгжүүлэгчдэд өгөхийн зэрэгцээ хөндлөгийн хяналт, үнэлгээ хийнэ.

Мал амьтны амьдрах нөхцлийн арга хэмжээнүүд нь мал амьтны зан төлөв, физиологи, үр шим, үржлийн талаарх мэдээлэл, хорогдлын түвшин, өвчин, гэмтэл зэрэг юм. Мал амьтны байр, хоол тэжээл, эрүүл мэнд зэрэгт анхаарал тавих нь тэдний амьдрах нөхцөл байдал, үр шим, үүнээс орж ирэх ашиг орлогыг нэмэгдүүлнэ. Мал амьтдын амьдрах нөхцлийг зөв зохистой зохицуулж шийдвэрлэсэн талаар өөр хэмжүүрүүд дээр суурилан бүтээмжийг үнэлэх шаардлагатай. Уг төсөл нь зөвхөн малын ашиг шимийг нэмэгдүүлээд зогсохгүй мал амьтны амьдрах таатай нөхцлийг бий болгоход анхаарч ажиллана. Иймд малчид, тариаланчид, хоршоо аж ахуйн нэгжүүд дор дурдсан шаардлагуудыг мөрдөх хэрэгтэй. Үүнд:

- Малыг бэлчээрлүүлж, ханатал нь услаж байгаа эсэхийг хянах
- Малыг торонд хашихгүй, хашаанд хатаахгүй байх
- Мал сүрэг байгалиас заяасан зан үйлээ илэрхийлэх эрх чөлөөг үл хязгаарлах
- Малыг хэт халах, хүйтэнд хөрөх, салхинаас хамгаалсан байранд байлгах
- Үхэрийг нь бусад бог малтай харьцуулахад илүү том зай талбайд байлгах
- Мал төллөх болон эмчлэх үеийн тусгаарлалтаас бусад тохиолдолд сүргээс нь салгахгүй байх
- Малын хашаа байрыг үргэлж цэвэр байлгах

6.5 Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамруулах журам

Энэ хэсэгт төслийн байгаль орчин, нийгмийн журмыг танилцуулна. Дор үзүүлсэн загвар, дарааллын дагуу дэд төслийн байгаль орчин, нийгмийн анхан шатны үнэлгээг хийж, авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээг тодорхойлно.



Зураг 2 Дэд төслийн үнэлгээ хийх явц

Дэд төслийн анхан шатны үнэлгээ

Энэхүү шатанд дэд төсөлд байгаль орчин, нийгмийн анхан шатны үнэлгээ хийнэ. Ингэснээр:

- Тухайн дэд төсөл санхүүжүүлэхгүй жагсаалтад байгаа эсэхийг үнэлэх
- Дэд төслийн эрсдлийн зэргийг тогтоож, хойшид хийгдэх ажлыг тодорхойлох боломж бий болно.

Хүснэгт 7 Дэд төслийн эрсдлийн зэрэг тогтоох

Байгаль орчин, нийгмийн эрсдлийн зэрэг	Тодорхойлолт	Дагаж хийгдэх баримт бичиг
Өндөр	Тухайн төсөл байгаль орчин, хүний эрүүл мэндэд төрөл бүрийн ноцтой нөлөөлөл үүсгэх ба тэдгээр нөлөөллийн заримыг арилгах арга хэмжээ авах боломжгүй.	/ Дэд төслийг дэмжихгүй
Ноцтой	Тухайн төслийн нөлөөлөл олон чиглэлээр өндөр байж болох ч зарим нэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой.	/ Дэд төслийг дэмжихгүй
Дунд	Төслийн сөрөг нөлөө төдийлөн ноцтой биш ба авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ олон бий.	Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө Оролцогч талуудтай харилцах стратеги боловсруулах
Бага	Болзошгүй сөрөг нөлөөлөл бага.	Оролцогч талуудтай харилцах стратеги боловсруулах

Өндөр болон ноцтой эрсдэлтэй дэд төслийг санхүүжүүлэхгүй. Төслийн эрсдлийн зэрэглэлийг Банкны холбогдох мэргэжилтнүүд хянаж, баталгаажуулна.

Дэд төслийн бэлтгэл ажил

Дэд төслийн анхан шатны үнэлгээнд тулгуурлан нэмэлт ажил шаардлагагүй төслүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг хийж явна. Бусад төслүүдийн хувьд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Банкны шаардлагуудын дагуу нэмэлт материалуудыг боловсруулна.

Дэд төслийг зөвшөөрч, батлах

Энэ шатанд дэд төсөл хэрэгжүүлэгчийн бэлтгэсэн материалыг төсөл хэрэгжүүлэх нэгжийн мэргэжилтэн, зөвлөх болон Банкны мэргэжилтнүүд хянаж үзэн, баталгаажуулна.

Дэд төслийн хэрэгжилт, хяналт үнэлгээ

Дэд төсөл батлагдаж, хэрэгжиж эхэлсэний дараа байгаль орчин, нийгмийн хяналт үнэлгээ тогтмол хийгдэнэ.

- Дэд төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааг банкны шаардлагын дагуу хянах
- Дэд төслийн хэрэгжилтийн явцад нөлөөллийн зэрэг өөрчлөгдөж, нэмэгдвэл энэ тухай банкинд мэдэгдэх, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дэд төсөл дуусах, эцсийн шатны үнэлгээ

Төслийн хаалтын үнэлгээний үеэр төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээг мөн хийнэ.

6.6 Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, байгаль орчны хяналт үнэлгээ

Дэд төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл дунд гэж гарсан тохиолдолд байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө заавал боловсруулна. БОНМТ-г ДБ-ны БОНХ-ын бодлогын дагуу боловсруулж, дэд төслийн бүх талбайд холбогдох арга хэмжээг багтаасан байх ёстой. Энэхүү БОНХМБ-ын хүрээнд нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүдийг дэд төслийн загвар, барилга угсралт болон үйл ажиллагаа тус бүрийн үр дүнд хамааруулан боловсруулах бөгөөд байгаль орчны суурь мэдээлэлд үндэслэн нөлөөг тодорхойлно.

БОНМТ-нд нь БОНМТ-г хэрэгжүүлэхэд оролцож байгаа байгууллагуудыг үүрэг, хариуцлагыг тодорхойлох шаардлагатай. Эдгээр байгууллагууд нь сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг сааруулах эсвэл бууруулах зорилгоор төслийн барилга угсралтын өмнөх шат, барилга угсралтын болон ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаануудыг тасралтгүй сайжруулахыг эрмэлзэнэ. БОНМТ нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Хэрэгжүүлэгч байгууллагууд ба тэдгээрийн үүрэг хариуцлага
- Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ
- Хяналт шинжилгээний төлөвлөгөө
- Тайлан гаргах
- Сургалт, чадавхийг сайжруулах, мэдлэг олгох
- БОНМТ-ийн өртөг
- Санал хүсэлт, Зохицуулга хийх механизм

Дэд төслийн БОНМТ-г боловсруулж, холбогдох байгууллага эсвэл ТХН-аар батлуулсны дараа түүнийг хэрэгжүүлнэ. БОНМТ-г хэрэгжүүлэх явцад байгаль орчин, нийгмийн асуудлын хяналт шинжилгээг урьдчилан төлөвлөсөн хуваарийн дагуу ХХААХҮЯ-ны ТХН-ийн БОНХС-ын дагуу гүйцэтгэнэ. Барилгын ажлын үе шатанд бага хэмжээний барилгын ажил гүйцэтгэгчид нь газар шорооны ажил, цэвэрлэх байгууламж, гарц зам барих, гэрлэн дохио байрлуулах зэрэг ажлуудын сөрөг нөлөөг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд шаардлагын гүйцэтгэх ёстой. (Байгаль орчныг хамгаалах талаар бага хэмжээний барилгын ажлыг гүйцэтгэхэд тавих шаардлагыг Хавсралт 2-т үзүүлсэн).

Байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг төслийг хэрэгжүүлэх явцад БОНМТ-тэй хэр нийцэж байгааг тодорхойлох зорилгоор ашигладаг. Байгаль орчинд хяналт шинжилгээ хийх үндсэн зорилго нь:

- тухайн төлөвлөсөн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хэмжээг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээтэй харьцуулах замаар барилгын компани/гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг үнэлэх,
- нөхөн сэргээх арга хэмжээ, хяналт шаардсан аливаа нөлөөлөл нь хэзээ ч эргэн нөхөгдөхгүй шинж чанартай эсэхийг тодорхойлох,
- шаардлагатай тохиолдолд байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээг сайжруулах санал гаргах.

Байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг тогтмол болон үе үе мониторинг хийх замаар баталгаажуулна. Барилга угсралтын болон ашиглалтын үе шатанд байгаль орчны хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааг доорхи хүснэгтүүдэд үзүүлэв.

Хүснэгт 8 Барилгын угсралтын үе шатанд хийгдэх хяналт шинжилгээ

Но.	Хяналт шинжилгээний шалгуур	Хяналт	Хяналт	Хариуцах ажилтан
-----	-----------------------------	--------	--------	------------------

	үзүүлэлт	шинжилгээний төрөл/ Хяналт шинжилгээний аргачлал	шинжилгээ хийх давтамж	
1	Орчин тойрны газар, авто замаар барилгын материалыг аюулгүй тээвэрлэх	Ажиглан хянах Үргэлжилсэн	Барилгын ажлын явцад тогтмол	Жижиг барилгын ажлын гүйцэтгэгч
2	Ухсан материалын овоолго ба зохих аргаар зайлуулах	Ажиглан хянах	Барилгын ажлын явцад тогтмол	Сум, жижиг барилгын ажлын гүйцэтгэгч
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажилчдын аюулгүй байдлын төхөөрөмжийн ашиглалт	ХХХ-ийг ашиглах Ажиглан хянах	Барилгын ажлын явцад тогтмол	Жижиг барилгын ажлын гүйцэтгэгч
4	Оршин суугч, ажилчид, гэр хорооллын оршин суугчдын аюулгүй байдал	Гэмтэл эсвэл ослыг бүртгэх	Барилгын ажлын явцад тогтмол	Сумын засаг захиргаа
5	Гэр хорооллын оршин суугчид тав тухгүй байдал үүсгэх, ус нэвчих гэх мэт	Ажиглан хянах Үргэлжилсэн	Барилгын ажлын явцад тогтмол	Сум, жижиг барилгын ажлын гүйцэтгэгч
6	Хатуу хог хаягдлыг ангилан зайлуулах	Ажиглан хянах	Барилгын ажлын явцад тогтмол	Сум, жижиг барилгын ажлын гүйцэтгэгч
7	Мод огтлох/ тайрах	Үргэлжилсэн	Барилгын ажлын явцад тогтмол	Сум, жижиг барилгын ажлын гүйцэтгэгч

Хүснэгт 9 Барилгын ашиглалтын үе шатанд хийгдэх хяналт шинжилгээ

Но.	Хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлт	Хяналт шинжилгээний төрөл/ Хяналт шинжилгээний аргачлал	Хяналт шинжилгээ хийх давтамж	Хариуцах ажилтан
1	Хатуу хог хаягдлын менежментийн систем	Хог хаягдлыг цуглуулсан устгасан бүртгэл	Хагас жил тутам	Сум/ ТХН
2	Ажилтан, албан хаагчдад аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар хийгдсэн сургалт, чиг баримжаа олгох үйл ажиллагааны тоо	Зохион байгуулсан сургалт, чиг баримжаа олгох үйл ажиллагааны тоо	Тогтмол	Сум/ ТХН
3	Хяналт шинжилгээний тайлан бэлтгэх ба нөлөөллийн аудит хийлгэх	Хяналт шинжилгээний тайланг бэлтгэх, БОМТ-ийг дагаж мөрдөх	Хагас жил тутам	Сум/ ТХН
4	Амьтны эрхийг хамгаалах стандарт, журамтай нийцтэй байдал	Амьтны эрх хамгаалах талаар мөрдөх журам Дулаан орон байр, ус, хоол зэрэг	Жилд нэг удаа	Сум/ ТХН
5	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны журамтай нийцтэй байдал	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сургалтын бүртгэл, авч хэрэгжүүлэх арга	Жилд нэг удаа	Сум/ ТХН

Но.	Хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлт	Хяналт шинжилгээний төрөл/ Хяналт шинжилгээний аргачлал	Хяналт шинжилгээ хийх давтамж	Хариуцах ажилтан
		ХЭМЖЭЭ		

Барилгын компани/гүйцэтгэгч нь БОМТ-д тодорхойлсон бүх арга хэмжээ, журмыг дагаж мөрдөж ажиллана. Монгол Улсын Засгийн газраас баталсан төлөвлөгөөнүүдэд ДБ-ны БОНХБ-ын шаардлагын дагуу хяналт шинжилгээ хийнэ. Бага хэмжээний барилгын ажилтай холбоотой нөлөөллийг бууруулах арга хэмжээг барилгын ажлын гэрээнд тусгах бөгөөд бага хэмжээний барилгын ажил гүйцэтгэгч компаниуд тухайн гүйцэтгэх ажлыг бүхэлд нь хариуцна. Түүнчлэн, барилгын ажлын гүйцэтгэгч жижиг компаниуд БОМТ-ний үйл ажиллагааны хэрэгжилтийн явцын тайланг сар бүр гаргаж өгнө. ТХН нь БОНХС-ын дагуу БОМТ-ийн тайлант хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагаа, явц, ололт амжилтын талаарх ДБ-нд улирал тутам тайлагнана. Явцын тайланд хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны тодорхойлолт, тэдгээрийн нөхцөл байдал; эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцох хуулийн этгээдийг тодорхойлох; төслийн менежментийн хуваарь, хугацааг холбогдох зардлын хамт тусгана.

7. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

7.1. Төслийг хэрэгжүүлэх байгууллагууд: Үүрэг, Хариуцлага

Хүнс, хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХААХҮЯ) нь төслийн хүлээн авагч байгууллага бөгөөд Японы Нийгмийн Хөгжлийн Сан төслийг хариуцсан Төслийн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийг байгуулна. ТУЗ нь төслийн өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгжилт, зохицуулалтыг хариуцах ба зөвлөлийг Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл (МАОЭЗЭНТ)-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн Төслийн Зохицуулагч удирдана. Үндсэн ажилтанд Ажлын удирдамжийн (АУ)-ын дагуу сонгон шалгаруулалтын дүнд сонгогдсон мэргэжилтнүүд тухайлбал мал аж ахуйн сургалт шинэчлэлт хариуцсан мэргэжилтэн, цахим хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн болон үзэсгэлэн худалдаа хариуцсан мэргэжилтэн багтана. Зөвлөл нь МАОЭЗЭНТ-ийн ТХН-ийн хяналт шинжилгээ, аюулгүй байдал, олон нийтийн итгэлд суурилсан удирдлагын тогтолцоо болон бусад холбогдох ажлуудад туслалцаа үзүүлнэ. Төслийн Удирдах Зөвлөл нь дараах үүргийн хүлээнэ: (i) төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратегийг боловсруулах, (ii) төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч агентлагууд болон талбай дахь чиглүүлэгч хоорондын хамтын ажиллагааг хангах, (iii) дижитал агуулгыг хөгжүүлж үйлчилгээнд нэвтрүүлэхэд манлайлан оролцох, (iv) ноос ноолуурын салбарт тэргүүлж байгаа аж ахуйн нэгж/компаниуд болон бусад үйлчилгээ үзүүлэгчидтэй түншлэлийг хөгжүүлэх; (v) МАОЭЗЭН Төслийн худалдан авалт, итгэлцлийн үйл ажиллагааг ТХН- хамтран зохицуулах; (viii) хяналт шинжилгээг хийж тайлагнах болон протоколыг шалгах.

Техник Туслалцааны Агентлаг. Дижитал Грийн нь хөдөө аж ахуй, эрүүл мэнд болон хоол тэжээлийг сайжруулах зорилготой технологи, нийгмийн байгууллагуудыг нэгтгэдэг, дэлхийн хэмжээнд танигдсан ашгийн бус хөгжлийн байгууллага юм. Төслийн техник туслалцааны Дижитал Грийн агентлаг нь өөрсдийн боловсон хүчинтэй бөгөөд (i) төсөлд хэрэглэх дижитал платформыг урьдчилан төсөөлөх, боловсруулах, түгээх, (ii) малын эрүүл мэнд, ашиг шим, ноос, ноолуурын салбарт ажиллаж байгаа үйлдвэр эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан сургалт, аж ахуйн нэгжийн сургалт, эмэгтэй үр ашиг хүртэгчдэд зориулсан хоолны дэглэм, хоол тэжээл, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх чиглэлээр илүү шинэлэг, чанартай мэдлэгүүдийг багтаасан агуулга бүхий сургалтыг томоохон сургалтын төвөөр дамжуулан зохион байгуулж орон нутгийн хамтрагч, гол агентлагуудыг


хамруулах, (iii) дижитал платформтой нэгтгэхийн тулд бусад дижитал үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх, (iv) ХХААХҮЯ / Дэлхийн банкинд техникийн хяналт болон тайлан гаргахад мэдээллээр хангах зэрэг ажилд манлайлан оролцоно. Дижитал Грийн нь орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах, "олон нийтийн" ба "олон нийтэд зориулсан" дижитал шийдлүүдийг хэрэгжүүлэх үйл явцад нэгдэхэд хөдөө орон нутгийн иргэдийг дайчлан ажиллахад мэргэшсэн байгууллага юм. Дижитал Грийн нь ядуу, эмзэг бүлгийн өрхүүдтэй ажиллаж байсан туршлагатай бөгөөд Энэтхэг, Этиоп, Афганистан, Бангладеш, Гана, Гвиней, Малави, Мозамбик, Нигер, Сенегал, Танзани зэрэг орнуудад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Тэд өргөтгөлийн систем, мэдээлэл, боловсрол болон харилцаа холбооны (IEC) компанит ажлыг хөгжүүлэх зорилгоор зан үйлийн талаархи ойлголтын судалгаанд тулгуурлан хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн салбарт хэрэгжүүлж буй Дэлхийн Банкны хэд хэдэн төслүүдтэй хамтран ажилласан болно.

Чиглүүлэгч Агентлаг. Төслийн хүрээнд хэрвээ хөдөө орон нутгийн малчдыг цахим хоршоонд элсүүлэх, тэднийг чадавхижуулах, малчдын хоршоонд үзүүлэх үйлчилгээг чиглүүлэх шаардлагатай бол ТББ, ИНБ, мэргэжлийн холбоод ба/ эсвэл хөгжлийн агентлагууд зэрэг Чиглүүлэгч Агентлагийг ажиллуулж болно Туршилтыг гүйцэтгэхдээ NEST Академи, START Монгол зэрэг Монголд амжилттай хэрэгжижи байгааа финтек, Мэдээлэл Технологийн гарааны бизнесүүдтэй хамтран ажиллахыг эрмэлзэнэ. Өрсөлдөөнтэй элсэлт эсвэл мини инновацийн сорилт нь ТХН, Дижитал Ногоонтой хамтран ажиллах боломжтой инновацийн чадавхитай түншүүдийг тодорхойлоход туслах бөгөөд Дижитал Ногоон дагалдсан орон нутгийн экосистемийг бий болгоход туслах болно. Энэхүү арга барилын гол зорилго нь туршилтын төсөл дууссаны дараа платформыг ажиллуулах, шинэчлэх үйл ажиллагааг гүйцэтгэх орон нутгийн чадавхийг бэхжүүлэхэд оршино.

7.2. Төслийн зохион байгуулалтын бүтэц

Төслийн түвшинд ХХААХҮЯ, техник туслалцааны болон чиглүүлэгч агентлагууд болон МААЭЗЭНТ төслийн ТХН-ийн хоорондын харилцан уялдааг Зураг 1-д харуулав.

Implementation Arrangements



Зураг 3 Төсөл хэрэгжүүлэх зохицуулалт

7.3. БОНХМБ-ын хэрэгжилтийн зохицуулалт

Байгаль орчны үнэлгээ, түүнчлэн БОНХМБ-ын хэрэгжилтийг хангахад Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж (ТХН) тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Төслийн зохицуулагч нь байгаль орчны үнэлгээ, хяналт шинжилгээг хийхэд ТХН-ийн Байгаль Орчны Мэргэжилтнээс туслалцаа авна. ТХН-ийн Байгаль Орчны Мэргэжилтний гүйцэтгэх үүрэгт хамгийн багадаа дараах үүргүүдийг хамруулна: (i) нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээг хийх зорилгоор бага хэмжээний барилгын ажил гүйцэтгэгчид болон бүх дэд төслүүдэд хяналт тавих; (ii) Орон нутгийн засаг захиргаа, дэд төслийг хэрэгжүүлэгчид болон бага хэмжээний *барилгын ажил гүйцэтгэгчидтэй* холбоо тогтоож хамтарч төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинтой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа авах; (iii) техникийн явцын тайлан, түүнчлэн байгаль орчны менежментийн тайланг 6 сар тутам бэлтгэх (ДБ-ний шаардлагаар).

7.4. БОНХМБ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх

Төслийг орон нутагт хэрэгжүүлэхийн өмнө төслийн орон нутгийн бүх ажилтнууд болон гүйцэтгэгчид зохих ёсоор бэлтгэгдсэн байх ёстой. Сургалтын агуулгыг хүснэгт 9-д харуулав. Хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зурах үед Төслийн Үндэсний Зохицуулагч ба Байгаль орчны мэргэжилтэн ажилчдын үр чадварыг БОНХМБ-ын хүрээнд шаардлагатай үүрэг хариуцлагатай нийцэх эсэхийг хянаж шалгана. Ажилтан бүр төслийн аймаг/сумын түвшинд баримтлах БОНХМБ-ыг хангах, хэрэгжүүлэхэд шаардлагатай үр чадварыг эзэмшүүлэхийн тулд ямар нэмэлт сургалт шаардлагатайг тайлбарлаж өгөх ёстой.

БОНХМБ-ын талаар Байгаль орчны мэргэжилтэн нь Хяналт Шинжилгээ үнэлгээний мэргэжилтэнтэй хамтран хэлэлцүүлгийг удирдаж чиглүүлнэ. Чиглүүлэх уулзалтаар нь дараах сэдвүүдийг хэлэлцэнэ:

- МААЭЗЭН төслийн үндсэн мэдээлэл ба өнөөгийн байдал,
- Төслийн зорилтот сумдын нийгэм, байгаль орчны нөхцөл байдлын талаарх тойм мэдээлэл,
- МААЭЗЭНТ-ийн ТХЗ болон төлөвлөсөн үйл ажиллагаа, боломжит боловсруулах цех/үйл ажиллагааг төслийн хүрээнд төлөвлөсөн хөрөнгө оруулалт, зохицуулалт, хяналт, тусламж гэх мэт зүйлсээр дамжуулан дэмжих боломжтой,
- Ажилтнууд ба зөвлөхүүдийг танилцуулах, тэдний үүрэг хариуцлага,
- Төсөлд санал гаргагчдыг танилцуулах,
- Хэрэгжүүлэх чухал стандартууд болон тэдгээрийн хэрэглээ, хяналтыг танилцуулах,
- БОНХМБ-той холбоотой ажлын тодорхой үүрэг, хүлээлт,
- Хяналт, хяналт шинжилгээний үйл явцын талаархи танилцуулга,
- Байгууламж, тоног төхөөрөмж болон ложистикийн тойм,
- БОНХМБ болон БОМТ-ний хяналт шалгалтын үр дүн,
- Зарчмуудын тухай танилцуулга жишээлбэл: санал гаргагч болон оролцогч талуудтай харилцах, мэдээлэл цуглуулах, хээрийн талбайн хяналт тавих гэх мэт,
- Хяналт шинжилгээний хуваарь болон бусад мэдээллийн танилцуулга.

Сургалт бүр тодорхой хөтөлбөрийн дагуу хамгийн багадаа 1-2 хоног үргэлжлэх бөгөөд асуудлыг интерактив аргаар шийдвэрлэх даалгавруудыг багтаасан байх ёстой. Сургалтын хөтөлбөрийг зөвлөх боловсруулж төсөл хэрэгжүүлэх явцад ТХН-тэй гэрээ байгуулна. Сургалтын үр дүнг үнэлж, төслийн явцын тайланд тусгана.

Сургалтын сэдэв	Сургалтын зорилгын хураангуй ба агуулга	Оролцогч	Давтамж болон зорилтот он сар өдөр	Сургалтын тооцоолсон зардал (ам доллар)
БОНХМБ-ын танилцуулга	Төсөл хэрэгжих газар нутгийн талаарх мэдээлэл, бохирдлын эрсдэл ба хяналт, БОНХ журмууд, ОТХЗТ, ХХЗЖ болон ГШМ зэргийг багтаасан БОНХМБ-ийн тойм	Төслийн бүх ажилчид/орон нутгийн ажилтнууд, гүйцэтгэгч байгууллагууд	Хөдөлмөрийн гэрээ/гэрээний эхэнд	3000
Байгаль орчин, нийгмийн хэрэгслүүд	Төслийн байгаль орчин, нийгмийн журмууд, ОТХЗТ, ХХЗЖ, ГШМ. Ковид-19-той холбоотой хязгаарлалтууд.	Төслийн бүх ажилчид/орон нутгийн ажилтнууд, гүйцэтгэгч байгууллагууд	Хөдөлмөрийн гэрээ/гэрээний эхэнд	3000
БОНХМБ-ын сургалт	Шинээр оруулсан өөрчлөлт, шинэчлэлтийг багтаасан БОНХМБ-ын хэлэлцүүлэг	Төслийн бүх ажилчид/гэрээлэгчид	Ажиллаж эхэлснээс хойш нэг жилийн дараа, эсвэл шаардлагатай тохиолдолд илүү олон удаа хийх	3400
Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын Ерөнхий менежмент; Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө; Хог Хаягдлыг дахин боловсруулах болон ашиглах, цэвэрлэх болон устгах; Аюултай хог хаягдлын менежмент; Хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх, цэвэрлэх болон устгах; Хог хаягдлыг цэвэрлэх Төрийн өмчит болон хувийн Гэрээлэгчид; Жижиг хэмжээний аюултай хог хаягдлын хяналт	Бүх Оролцогч Талууд	Төслийн хүрээнд	3000
Ноолуур болон мал аж ахуйн салбарын байгаль орчны асуудал	Мал аж ахуй, ноолуурын салбар дахь нөөцийн үр ашиг, бохирдлын болон ХАБЭА-н менежмент, мал амьтны амьдрах орчныг сайжруулах	Цахим хоршооны гишүүд/малчид	Төслийн хүрээнд	7000
Бага хэмжээний барилгын ажилд зориулсан байгаль орчны сайн туршлагын дүрэм, нөөцийн үр ашиг,	Бага хэмжээний барилгын ажилд тавигдах байгаль орчны болон ХАБЭА-н шаардлагууд	Бага хэмжээний барилгын ажил гүйцэтгэгч	Бага хэмжээний барилгын ажлыг хийж эхлэхээс өмнө	5000

бохирдлын менежмент				
Амьтны эрх, сайн сайхан байдал	Оролцогч талуудын зайлшгүй дагаж мөрдөх стандарт, журмыг танилцуулна	Бүх оролцогч талууд	Төслийн хүрээнд	4000

8. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ОРОЛЦОО

8.1. Төслийг Бэлтгэх Үеийн Олон Нийтийн Хэлэлцүүлэг

Төслийн зураг төсөл, Байгаль орчин нийгмийн хамгааллын менежментийн бодлого (БОНХМБ) эцэслэхийн өмнө төслийн саналыг танилцуулан, төслийн зураг төсөл болон БОНХМБ-д эргэн санал зөвлөмжийг хүлээн авах зорилгоор олон салбарын төлөөллийг оролцуулан хэд хэдэн удаагийн зөвлөлдөх болон олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагааг нэгтгэн харууллаа.

Хүснэгт 11 Оролцогч талуудтай урьдчилан Зөвлөлдөх /Олон нийтийн хэлэлцүүлгийн эмхэтгэл

Но.	Огноо ба Байршил	Оролцогч (ид)	Сэдэв	Үр дүн
1	2020 оны 9 дүгээр сарын 9 Цахимаар ярилцах	Батсүх, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал амьтны эрүүл мэндийн албаны захирал Ханимхан, ХАА-н үйлдвэрлэлд ШУ-ны ололт нэвтрүүлэх төв. Эрхэмбаяр, Монголын Малзүйч, Үржүүлэгчдийн Холбооны Ерөнхийлөгч Алтантуяа, Монголын ХАА-н Хоршоологчдын Үндэсний Холбоо Дондогдорж, ХХААХҮЯ	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Малчдыг цахим хоршоонд татан оролцуулах нь нэлээд ярвигтай асуудал бөгөөд бодит амьдрал дээр малчдын олон хоршоо сайн ажилладаггүй. Эхний ээлжинд хоршоодыг цахим хоршоонд нэгтгэх бөгөөд дараагийн шатанд малчдыг хамруулах нь зүйтэй. Төслийн үзэл баримтлал, үйл ажиллагаа, стратегитэй санал нийлж байна.
2	2020 оны 9 дүгээр сарын 10 Цахимаар ярилцах	Батцэнгэлийн Болор-Эрдэнэ, Монголын Харилцаа холбоо, Мэдээллийн Технологийн Газрын дарга (ХХМТГ)	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, түүний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Засгийн газраас Хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх үйлчилгээг цахим засаглалын платформтой уялдуулах хэрэгтэй бөгөөд ХХААХҮЯ нь өөрийн дижитал үйлчилгээгээ үүнд нэгтгэхээр төлөвлөсөн болно. Олон үе шаттай хэрэгжүүлэх нь ухаалаг арга гэж үзэж байна: цөөн газарт эхний туршилтыг ("лаборатори") хийж ололт амжилтаа тодорхойлно; ХХААХҮЯ нь өөрийн платформыг

				хөгжүүлсний дараагаар амжилттай хэрэгжүүлсэн туршлагауудыг нэвтрүүлэх боломжтой.
3	2020 оны 9 дүгээр сарын 10 Цахимаар ярилцах	Цээлэйн Энх-Амгалан, Швейцарийн засгийн газрын санхүүжилттэй Ногоон алт төслийн менежер	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, түүний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийн үзэл баримтлал, үйл ажиллагаа, баримтлах бодлоготой санал нийлж байна. Малчид бог, бод зэрэг холимог төрлийн малтай тул төрөлжүүлэхэд анхаарах хэрэгтэй: Сарлагийн хөөврийг "3-р зэрэглэлийн ноолуур" -тай дүйцүүлдэг, ургамлын гарц бүхий бэлчээрт ээлтэй, ашиг шим сайтай.
4	2020 оны 9 дүгээр сарын 10 Цахимаар ярилцах	Эрико Тамура, ЖАЙКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газрын дарга	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, түүний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийн үзэл баримтлалд санал нэгдэж хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн. Алслагдсан хөдөө орон нутагт сүлжээнд холбогдох нь бэрхшээлтэй бөгөөд зөвхөн аймгийн төвүүдэд энэ боломж бүрдсэн байдаг.
5	2020 оны 9 дүгээр сарын 10 Цахимаар ярилцах	Винод Ахужа, НҮБ-ийн ХХААБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Мишагийн Амартогтох, Монголын мал амьтны эрүүл мэндийг тодорхойлох систем (МАЭМТС)	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Одоо байгаа төрөл бүрийн платформ, мэдээллийн санг нэгтгэх асуудлыг хөндсөн.
6	2020 оны 9 дүгээр сарын 16 Цахимаар ярилцах	Энх-Ирээдүй, Хаан Банкны ЖДҮ-ийн бизнесийн алба, хэлтсийн дарга Билгүүн, Хаан Банкны ЖДҮ-ийн бизнесийн алба, менежер Уламбаяр, Хас Банкны Иргэдийн банк хариуцсан захирал Алтанзул, TransCapital NBFI-ны Гүйцэтгэх захирал	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийн үзэл баримтлал, үйл ажиллагаа, баримтлах бодлоготой санал нийлж байгаа бөгөөд хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах сонирхлоо илэрхийлсэн.
7	2020 оны 9 дүгээр сарын 16	Зуун мод сумын малчид, нутгийн захиргааны албан хаагчид	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож,	Төслийн үзэл баримтлал, үйл ажиллагаа, баримтлах бодлоготой санал нэгдэж байгаа бөгөөд дэмжиж ажиллана гэдгээ

	Төв аймгийн Зуун мод сум		зөвлөмжийг хүлээн авсан.	илэрхийлсэн. Малчдыг цахимжуулалтад хамруулах нь чухал асуудал юм.
8	2020 оны 9 дүгээр сарын 16 Төв аймгийн Эрдэнэ сум	Эрдэнэ сумын малчид, нутгийн захиргааны албан хаагчид, малчдын хоршоо	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийн үзэл баримтлал, үйл ажиллагаа, баримтлах бодлоготой санал нэгдэж байгаа бөгөөд дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлсэн. Малчдыг цахимжуулалтад хамруулах нь чухал асуудал юм.
9	2020 оны 9 дүгээр сарын 17 Цахимаар ярилцах	Энхбат, Юнител Группийн Гүйцэтгэх захирал Жулдиз, Юнител Группийн Бизнесийн хөгжил, мэдээллийн шинжилгээний хэлтсийн менежер	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Тэд олон төрлийн програм, хэрэгслүүдийг ашиглахыг санал болгоход бэлэн бөгөөд, хамтран ажиллах сонирхолтой
10	2020 оны 9 дүгээр сарын 17 Цахимаар ярилцах	Жамсранжавын Чанцалням, , “Тогтвортой ноолуур төсөл”, Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн Менежер, Монгол Жутта Реахг, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Техникийн ахлах мэргэжилтэн Цоодолын Нямхүү, ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ, ICT/IT Техникийн Зөвлөх Волоожийн Шинэнэмэх Тогтвортой ноолуурын платформ, НҮБХХ Монгол Жан Хинричс, АХБ-ны Байгаль орчин, байгалийн нөөц ба хөдөө аж ахуйн хэлтсийн Байгалийн нөөцийн ахлах эдийн засагч	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Дижитал хэрэгслийг ашиглах нь ирээдүйтэй; ноолуурын гарал үүслийг тогтоох бололцоог бүрдүүлэх (тус системийг ноолууранд амжилттай туршсан бөгөөд, мах боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг хэрэглэдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хэрэглэдэг), ноолуурын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг стандарттай уялдуулах; нөөцийн менежментийн уялдаа холбоо; ноолуурын салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой

11	2020 оны 9 дүгээр сарын 17 Улаанбаатар	Тацуя Хамада, Гүйцэтгэх захирал, Мобиком Корпорацийн Оюунчимэг, Мобиком Корпораци, Дижитал Бизнесийн хэлтсийн дарга Мөнхзориг, Мобиком Корпораци, МХХТ-ийн хэлтсийн захирал	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Тэд өөрсдийн олон төрлийн програм, хэрэгслүүдийг ашиглахыг санал болгоход бэлэн бөгөөд, хамтран ажиллах сонирхолтой
12	2020 оны 9 дүгээр сарын 18 Цахимаар ярилцах	Хиромичи Мияашита, Япон улсын Элчин сайдын яам	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, түүний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийн үзэл баримтлалыг сайшаасан ЖАЙКА-гийн төслүүдтэй холбох хүсэлт
13	2020 оны 9 дүгээр сарын 18 Цахимаар ярилцах	Байвалын Батхишиг, Тогтвортой Ноос, ноолуурын эвсэл, орон нутгийн захирал, Монгол	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, түүний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийн загварыг дэмжсэн: Алслагдсан малчдыг дижитал хэрэгслийг ашиглан өртгийн сүлжээнд холбох; маш их боломж бий гэж үзсэн.
14	2020 оны 9 дүгээр сарын 18 Цахимаар ярилцах	Ганхуягийн Ням-Очир, Монголын Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Намуулан, Монголын Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны сургалтын ажилтан	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх боломжтой Тоон технологийг цаг тухайд нь ашиглах
15	2020 оны 9 дүгээр сарын 18 Цахимаар ярилцах	Эрдэнэбаяр, ШУТИС-ийн Захирлуудын Зөвлөлийн дарга, багш Эрдэнэчулуун, ШУТИС-ийн Эдийн засгийн багш Батжаргал, ШУТИС-ийн Статистик ба математикийн эдийн засгийн багш	Төслийн үзэл баримтлалыг танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, зөвлөмжийг хүлээн авсан.	Төслийг дэмжихэд хангалттай мэдлэг, мэдээллийн нөөцтэй байх

8.2. Төсөл Хэрэгжүүлэх Явцын Олон Нийтийн Хэлэлцүүлэг

Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт нь удаан хугацааны бүтээлч, үр өгөөжтэй харилцааг хөгжүүлдэг. Энэ нь ХХААХҮЯ-нд төслийн үйл ажиллагаа болон үр дүнгийн талаар оролцогч талуудын санаа зовж байгаа асуудлыг ойлгоход туслах бөгөөд үүнийг нь төслийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд ашиглана. Мөн энэ нь эрт шатанд байгаль орчин, нийгмийн хамгааллын эрсдэл, үр нөлөөг тодорхойлсоноор урьдчилан сэргийлэх, нэн даруй арилгах боломжийг олгодог. Цахим хоршооны төсөлд ганцаарчилсан болон цахим уулзалт, бүлгийн хэлэлцүүлэг, чухал мэдээлэл солилцох ярилцлага болон зөвлөлдөх санал асуулга зэрэг хэлбэрийг ашиглана.

Төслийн эмзэг бүлгийн малчин өрхийг чадавхижуулах, эмэгтэйчүүдийг дэмжих зэрэг тэргүүлэх чиглэлийн хүрээнд ХХААХҮЯ нь эдгээр хүмүүсийн төслийн оролцогч талуудын уулзалтанд оролцох, төсөлтэй холбоотой мэдээ мэдээллийг хүлээн авахад учирч болзошгүй саад, бэрхшээлийг тодорхойлсон. Төслийн мэдээллийг ил тод болгох, оролцогч талуудын зөвлөлдөх тогтолцоог эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг бэрхшээл, сул талуудтай зохицуулдаг бөгөөд МААЭЗЭНТ-ийн ТХН нь эдгээр оролцогчдын хэрэгцээнд тохирох тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Зарим эмзэг бүлгийн өрхүүдэд уулзалтын газар ирэх тээврийн хэрэгсэл байхгүй эсвэл тэднийг эзгүйд орлох ажилтан байхгүй тохиолдолд ТХН нь төслийн мэдээлэл дамжуулах сургалт, оролцогч талуудын уулзалтыг тэдний шаардлагад нийцсэн, тэдэнтэй ойр байршилд зохион байгуулах, тээврийн хоолны мөнгөн дэмжлэг зэрэг зарим тусламжийг үзүүлж болно.

Хүснэгт 12 Төслийн олон нийтийн хэлэлцүүлэг

Но.	Оролцогч талууд	Олон нийтийн хэлэлцүүлэгийн сэдэв	Хэрэглэх аргачлал	Байршил/ Давтамж	Хариуцах эзэн
1	Төслийн үр ашиг хүртэгсэд	Төслийн танилцуулга, төлөвлөсөн үйл ажиллагааны мэдээлэл, холбогдох эрсдэл ба бууруулах арга хэмжээ Төслийн явц Төслийн үр дүн ба гол гүйцэтгэл	Бүлгийн ярилцлага Олон нийтийн арга хэмжээ Чухал мэдээлэл солилцох ярилцлага	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	ТХН
2	Орон нутгийн засаг захиргаа	Төслийн явцын шинэчилсэн мэдээлэл Төслийн хамтын ажиллагааны боломж Төслийн үр дүн ба гол ололт амжилт	Төслийн явцын сургалтууд Чухал мэдээлэл солилцох ярилцлага	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	ТХН
3	Ноос ноолуур боловсруулагч болон худалдан авагчид	Төслийн явц Төслийн хамтын ажиллагааны боломж	Олон нийтийн арга хэмжээ Сургалт	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	ТХН
4	Мал аж ахуйн үйлчилгээ үзүүлэгчид	Төслийн явц Төслийн хамтын ажиллагааны боломж	Олон нийтийн арга хэмжээ Сургалт	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	ТХН
5	ТББ болон	Төслийн явц	Олон нийтийн	Төсөл хэрэгжиж	ТХН

	ИНБууд	Төслийн хамтын ажиллагааны боломж	арга хэмжээ	байгаа сум/ Хагас жил тутам	
6	Орон нутгийн засаг захиргааны оролцогч талууд	Төслийн явцын шинэчлэсэн мэдээлэл Төслийн хамтын ажиллагааны боломж	Ганцаарчилсан уулзалт	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	ТХН

8.3. Мэдээллийг Ил Тод Болгох

Төслийн оролцогч талуудтай үр дүнтэй, ач холбогдол бүхий хэлэлцээр хийхийн тулд ХХААХҮЯ янз бүрийн арга хэрэгслийг ашиглана Төслийн зураг төсөл боловсруулах зөвлөлдөх уулзалтын үеэр малчил, төрийн хаагчид зэрэг оролцогч талууд мэдээлэл авах, санал солилцох хамгийн үр дүнтэй, ашиглаж болох арга хэрэгсэл нь ТВ, мессеж болон олон нийт уулзалт гэж тодорхойлсон. Түүнчлэн эдгээр арга хэрэгслээс гадна төслийн оролцогч талуудад мэдээллийг ил тод болгох зорилгоор МААЭЗЭНТ-ийн хэвлэлийн мэдээ, ХХААХҮЯ-ны вэбсайт болон бусад олон нийтийн сүлжээний вэбсайтуудыг ашиглана. ХХААХҮЯ нь төслийн нөлөөлөлд өртсөн талуудын төслийн байгаль орчин, нийгмийн хамгааллын гүйцэтгэлтэй холбоотой асуудал, санал гомдолд цаг тухайд нь хариу өгөх болно. Энэ зорилгоор Гомдол санал шийдвэрлэх механизмыг байгуулж төслийн оролцогч талуудтай өргөн хүрээнд харилцах болно.

Хүснэгт 13 Төслийн мэдээллийг ил тод болгох

Но.	Оролцогч талууд	Ил тод болгох мэдээллийн жагсаалт	Аргачлал	Байршил/ Давтамж	Хариуцах эзэн
1	Төслийн үр ашиг хүртэгсэд	БОНХ-ын хэрэгслийг оролцуулан төслийн талаарх мэдээлэл, төслийн үр ашиг, Гомдол шийдвэрлэх механизм	Уулзалтын мэдээлэл Фейсбүүк гэх мэт платформоор нийтийн сүлжээнд нийтлэл оруулах Хэвлэмэл материал	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	Төслийн үр ашиг хүртэгсэд
2	Орон нутгийн засаг захиргаа	Төслийн үр ашгийг багтаасан төслийн мэдээлэл ба шинэчлэлтүүд	Уулзалтын мэдээлэл Фейсбүүк гэх мэт платформоор нийтийн сүлжээнд нийтлэл оруулах Хэвлэмэл материал	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	Харилцаа холбоо, нөлөөллийн мэргэжилтэн
3	Ноос ноолуур боловсруулагч	Төслийн мэдээлэл,	Уулзалтын мэдээлэл	Төсөл хэрэгжиж байгаа сум болон	Харилцаа холбоо, нөлөөллийн

	болон худалдан авагчид	боломж шинэчлэлт ба	Фейсбүүк гэх мэт платформоор нийтийн сүлжээнд нийтлэл оруулах	Улаанбаатар/ Улирал тутам	мэргэжилтэн
4	Мал аж ахуйн үйлчилгээ үзүүлэгчид	Төслийн мэдээлэл, боломж шинэчлэлт ба	Уулзалтын мэдээлэл Фейсбүүк гэх мэт платформоор нийтийн сүлжээнд нийтлэл оруулах	Төсөл хэрэгжиж байгаа сум болон Улаанбаатар/ Улирал тутам	Харилцаа холбоо, нөлөөллийн мэргэжилтэн
5	ТББ болон ИНБууд	Төслийн мэдээлэл, боломж шинэчлэлт ба	Уулзалтын мэдээлэл Фейсбүүк гэх мэт платформоор нийтийн сүлжээнд нийтлэл оруулах	Төсөл хэрэгжиж байгаа сум болон Улаанбаатар/ Улирал тутам	Харилцаа холбоо, нөлөөллийн мэргэжилтэн
6	Орон нутгийн засаг захиргааны оролцогч талууд	Төслийн мэдээлэл, боломж шинэчлэлт ба	Уулзалтын мэдээлэл Фейсбүүк гэх мэт платформоор нийтийн сүлжээнд нийтлэл оруулах Хэвлэмэл материал	Төсөл хэрэгжиж байгаа сум болон Улаанбаатар/ Улирал тутам	Харилцаа холбоо, нөлөөллийн мэргэжилтэн
7	Хөгжлийн бэрхшээлтэй/ эмзэг бүлэг	Төслийн үр ашгийг багтаасан төслийн мэдээлэл ба шинэчлэлтүүд Гомдол шийдвэрлэх механизм	Уулзалтын мэдээлэл Хэвлэмэл материал Сургалт семинар	Төсөл хэрэгжиж байгаа сум/ Хагас жил тутам	Харилцаа холбоо, нөлөөллийн мэргэжилтэн

8.4. Гомдол Шийдвэрлэх Механизм

8.4.1. Гомдол Шийдвэрлэх Механизмын зорилго

Гомдол Шийдвэрлэх Механизм (ГШМ)-ын зорилго нь гомдол гарсан даруйд эсвэл тохиолдолд түүнийг шийдвэрлэхэд оршино. ГШМ-ыг зорилтот аймаг тус бүрт холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын хэрэгжүүлэлтийн дагуу байгуулна. ГШМ нь Төслийн Гүйцэтгэлийн Тайлан-г гаргах хүртэл төслийн хэрэгжилтийн үе шатанд нээлттэй хэвээр байна.

8.4.2. Гомдол шийдвэрлэх механизм

Оролцогч талуудын гомдлыг цаг тухайд нь үр дүнтэй шийдвэрлэх нь төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг бий болгоно. Ялангуяа энэ нь төслийн менежмент болон оролцогч олон нийтийн бүлгийн хооронд харилцаа бий болгох, бэхжүүлэх үйл явцад дэмжлэг болох бөгөөд завсардлыг арилгаж, нийтлэг ойлголтыг бий болгосноор төслийн менежментийг тухайн бүс нутагт үр дүнтэй хэрэгжихэд туслана. Одоогийн байдлаар ХХААХҮЯ нь Байгаль орчин, Нийгмийн Хамгааллын талаар тусгайлсан бодлого байхгүй. ДБ-ны Хамгааллын Бодлогын журамд зааснаар ХХААХҮЯ нь Байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд зориулсан Олон Нийтийн Гомдол Шийдвэрлэх Нэгж (ОНГШН) байгуулахыг шаарддаг бөгөөд төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсд тохирсон гомдол шийдвэрлэх журмыг бий болгох шаардлагатай. ГШМ нь нөлөөлөлд өртсөн хүмүүс / талуудын асуудал, гомдлыг цаг тухайд нь хурдан шуурхай шийдвэрлэх бөгөөд үүний тулд жендэрийн бодлогод нийцсэн, соёл ёс заншлын хувьд зохистой, нөлөөлөлд өртсөн хүмүүст үнэ төлбөргүй нэвтрэх боломжтой, ойлгомжтой, ил тод үйл явцыг ашиглана. Төсөлтэй холбоотой санал, гомдлыг МААЭЗЭН төслийн цахим хуудас болон ХХАХҮЯамны тусгай дугаар 109-р хүлээж авна. Энэхүү ГШМ нь Байгаль орчин, нийгмийн хамгааллын ОНГШН-ээс бүрдэх бөгөөд түүнийг ТХН-ийн Байгаль орчны мэргэжилтэн удирдан зохицуулна. ОНГШН-ийн бүрэлдэхүүнийг Хүснэгт 13-т жагсаан харууллаа.

Хүснэгт 14 Олон Нийтийн Гомдол Шийдвэрлэх нэгжийн бүтэц

1	ТХН-ийн Байгаль Орчин, нийгмийн хамгааллын мэргэжилтэн
2	ТХН-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн
3	ТХН-ийн Харилцаа холбоо, нөлөөллийн мэргэжилтэн

ОНГШН-ийн дараах үүрэг хариуцлагуудтай байна. Үүнд:

- Гүйцэтгэгч нь ирсэн санал гомдлыг шууд ОНГШН-д ирүүлэхийг зааварлана. Үүний нэгэн адил ОНГШН нь орон нутгийн захиргааны хэлтсүүдэд шууд ирэх санал гомдлыг хамтран зохицуулна,
- Ирүүлсэн гомдлыг тэмдэглэн авч, хүлээн авсан огноог мэдээллийн санд оруулах ба гомдлыг хүлээн авснаа Гүйцэтгэгч эсвэл холбогдох талуудад мэдэгдэх ёстой.
- Гомдлыг шалгаж, түүний үнэн зөвийг тодорхойлж, асуудлын эх үүсвэр нь төслийн үйл ажиллагаатай холбоотой эсэхийг үнэлж, зохих залруулга арга хэмжээ, хариуцах хүмүүсийг олж тодорхойлох,
- Хянан шалгах ажиллагааны үр дүн, авсан арга хэмжээний талаар Нөлөөлөлд Өртсөн Хүмүүс (НӨХ)-д мэдээлэх,
- Өргөдөл гомдлыг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас шилжүүлсэн тохиолдолд тогтоосон хугацаанд гомдлын хяналт шалгалтын байдал, үйл ажиллагааны талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад урьдчилсан тайлан хүргүүлэх.
- Гүйцэтгэгчийн тодорхойлсон залруулга арга хэмжээ, шинэчлэгдсэн байдлыг хянах,
- Шаардлагатай бол нэмэлт хяналт шалгалт хийж, гомдлын шалтгаан дахин үүсэхгүй байгаа эсэхийг шалгаж үзэх.

Энэхүү Гомдол Шийдвэрлэх Механизм (ГШМ) нь төслийн мэдээллийг цаг тухайд нь мэдээлэх замаар нөлөөлөлд өртсөн хүмүүс / талуудын ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэх үр дүнтэй арга барилыг бүрдүүлэх бөгөөд төслийн бүх түвшний томилогдсон ажилтнуудын холбоо барих мэдээллийг олон нийтэд ил болгож санал, гомдол гаргахад нээлттэй байлгах боломжийг бүрдүүлнэ.

Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн гомдлыг эхлээд ТХН-ийн Байгаль Орчны Мэргэжилтэнд хүргүүлнэ. Тэдгээрээс ирсэн шийдэгдээгүй гомдлыг ОНГШН-д өгч төсөл хэрэгжиж буй газар бүрийн төслийн хэрэгжилтэд хяналт тавина. ОНГШН нь санал гомдлын үр дүнг тодорхойлж, гомдлыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэнэ; үүнээс хэтэрсэн гомдлыг НӨХ зохих шатны шүүхэд шилжүүлнэ. ТХН нь хүлээн авсан бүх гомдлын бүртгэлийг хөтлөх бөгөөд үүнд: гомдол гаргагчийн холбоо барих хаяг, гомдлыг хүлээн авсан огноо, гомдлын шинж чанар, зөвшин хэлэлцсэн залруулах арга хэмжээ, шийдвэрлэсэн огноо, эцсийн үр дүн зэргийг багтаана. Гомдол Шийдвэрлэх алхамууд ба хугацааг Хүснэгт 14-д дараах байдлаар харуулав.

Хүснэгт 15 Гомдол Хянан Шийдвэрлэх Механизм

Алхам 1	ГШМ-д оролцох. Хэрэв ямар нэгэн асуудал гарвал НӨХ тухайн асуудлаа гэрээлэгчтэй шууд шийдвэрлэх, гомдол байвал Олон Нийтийн Гомдол Шийдвэрлэх Нэгж-д шууд мэдээлэх, эсвэл Баг, сумын удирдлагууд зэрэг өөрт нь харилцахад хялбар удирдлагуудтай харилцах.
Алхам 2	ОНГШН-д ирэх албан ёсны гомдол. Баг/сумын түвшинд гомдол гарвал, баг/сумын төлөөллүүд ОНГШН-д гомдлыг аман болон бичгэн хэлбэрээр хүргэнэ. Аман гомдлыг ОНГШН бичгэн тэмдэглэл хийж бүртгэх ёстой. ОНГШН нь гомдол бүрийн хамааралтай эсэхийг шалган үнэлэх ёстой. Хэрэв гомдол хамааралгүй бол, жишээлбэл асуудал гомдол нь төслийн хамрах хүрээнээс гаднах зүйлстэй холбоотой байх тохиолдолд, ОНГШН нь ажлын тав хоногийн дотор НӨХ-д тодорхой хариу өгөх болно.
Алхам 3	ОНГШН-ийн Гомдол Шийдвэрлэсэн Шийдвэр. ОНГШН нь хамааралтай гомдлыг бүртгэнэ. ОНГШН нь ТХН-ийн Байгаль Орчны Мэргэжилтний дэмжлэгтэйгээр асуудлыг судалж шийдвэрлэх алхмууд хийнэ. Энэ нь гүйцэтгэгчийг залруулга арга хэмжээ авахыг зааварчлах бөгөөд шийдвэрлэх хугацаа болох долоо хоногийн хугацаанд гүйцэтгэгч нь шийдвэрлэх шийдийг хэрэгжүүлж, үр дүнг ОНГШН-д хүргүүлнэ.
Алхам 4	Оролцогч талуудын уулзалт. Хэрэв Здахь Шатны үед ОНГШН нь шийдэл олж чадахгүй эсвэл НӨХ нь санал болгосон шийдэлд сэтгэл хангалуун бус байвал Здахь Шат дууссанаас хоёр долоо хоногийн дотор холбогдох сумын засаг Даргын нэрэмжит бүх холбоотой оролцогч талуудын дунд уулзалтыг ОНГШН зохион байгуулна. Уулзалтын үр дүнд бүгдэд нийцсэн шийдэлд хүрч, үүрэг хариуцлага болон үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлсон байх ёстой. Гүйцэтгэгч нь долоо хоногийн хугацаатайгаар эдгээр шийдлүүдийг хэрэгжүүлж үр дүнг ОНГШН-д хүргүүлнэ.
Алхам 5	Аймгийн Засаг Даргын шийдвэр. Хэрэв оролцогч талуудын дунд зохион байгуулсан уулзалтын үр дүнд шийдэлд хүрч чадаагүй, НӨХ нь сэтгэл хангалуун бус байвал ОНГШН нь холбогдох аймгийн засаг даргатай уулзаж шийдэл гаргах.

Төслийн хэрэгжилтийн ГШМ-ыг вэб ашиглан хэрэгжүүлэх төсөвт өртөг нь 5000 ам.доллар. БОНХМБ-ыг бүхэлд нь хэрэгжүүлэхэд нийт төсөвт өртөг нь 30 000 ам.доллар байна.

Дэлхийн банкны Тусгай Үүрэг. Хэрэв аймгийн Засаг дарга гомдлын талаар шийдвэр гаргаж чадахгүй бол ОНГШН нь ДБ-нд мэдэгдэж, ДБ нь асуудлыг шийдвэрлэх тусгай үүргийг эхлүүлнэ. Хэрэв НӨХ үүнээс гарах үр дүнд нь сэтгэл хангалуун бус хэвээр байгаа бол орон нутгийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

Дэлхийн Банкны Санал Гомдол Шийдвэрлэх Үйлчилгээ (ДБСГШҮ). Дэлхийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төсөл нь иргэд, олон нийтэд сөрөг нөлөө үзүүлсэн эсвэл нөлөөлж болзошгүй гэж иргэд үзэж байгаа тохиолдолд ДБСГШҮ нь иргэд, олон нийтийг ДБ-нд

шууд гомдол гаргах нэмэлт арга замыг санал болгодог. ДБСГШҮ нь Дэлхийн Банкны хариу үйлдэл, хариуцлагыг дээшлүүлж, гомдлыг цаг алдалгүй шалгаж, хариу арга хэмжээ авах болон хамтарч ажилласнаар амуудал, шийдлийг хурдан шуурхай тодорхойлоход нөлөөлдөг.

ДБСГШҮ-ний хариуцлагын механизм. Үүнээс гадна нөлөөнд өртсөн хүмүүс холбоо барих буюу гомдлоо ДБ-ны ГШҮ-д дараах хаягуудаар дамжуулан өгөх боломжтой бөгөөд мэдээллийг дэд төслийн талбай дахь самбарт байршуулдаг.

СГШҮ нь дараах гомдлыг хүлээн авдаг:

- ДБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа төсөлтэй холбоотой (ОУСБХБ эсвэл ОУХН)
- Дэлхийн Банкнаас санхүүжүүлсэн төслийн үйл ажиллагаа өөрт нь сөргөөр нөлөөлсөн гэж үзэж байгаа хүн эсвэл олон нийтээс гаргасан өргөдөл
- Дэлхийн Банкны санхүүжилтээр байгуулсан гэрээний дагуу худалдан авах ажиллагааны талаар тендер, боломжит тендер оролцогчоос ирүүлсэн өргөдөл

Гомдол нь заавал:

- Гомдлын үндсэн агуулгыг тодорхойлох
- Төслийн сөрөг нөлөөл (лүүд) ийг тодорхой зааж өгөх
- Гомдол гаргаж буй хүнийг тодорхойлж, нууцийг шаардсан эсэхийг тодруулах
- Гомдлыг тухайн төслийн нөлөөлөлд өртсөн хүн (хүмүүс) эсвэл олон нийтийн төлөөлөгчөөр ирүүлсэн эсэхийг тодорхойлох
- Гомдлыг нийтийн төлөөлөгч ирүүлсэн тохиолдолд түүний нэр, гарын үсэг, холбоо барих хаяг, төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар бичгээр өгсөн нотолгоог оруулна
- Нотлох баримт шаардлагагүй боловч гомдлыг хянаж шийдвэрлэхэд тустай байж болно. Гомдлын хэсэгт хүмүүс тухайн гомдлыг хэрхэн шийдвэрлэх боломжтой гэж үзэж байгаа саналаа оруулах боломжтой. Хүсэлтийн дагуу гомдол гаргагчийн хувийн мэдээллийг нууцлах болно. Дэлгэрэнгүй зааврыг <http://www.worldbank.org/grs> дээрээс авна уу.

СГШҮ нь гомдлыг англи хэл дээр эсвэл гомдол гаргасан хүний тухайн улсын албан ёсны хэл дээр хүлээн авдаг. (ДБ-ны Гомдлыг шийдвэрлэх үйлчилгээний гомдлын хуудсыг Хавсралт 3-т тусгасан). СГШҮ-т мэдүүлгийг дараах хаягаар илгээнэ үү:

Email: grievances@worldbank.org

Fax: +1-202-614-7313

Letter: The World Bank Grievance Redress Service (GRS)

MSN MC 10-1018

1818 H St NW

Washington, DC 20433, USA

Тайлан гаргах. ОНГШН нь гомдол, шалгах үйл явц, дараагийн үйл ажиллагаа болон үр дүнг тэмдэглэнэ. Аймгийн түвшний Төслийн Дэмжлэг Үзүүлэх Бүлэг (ТДҮБ) энэ мэдээллийг ТХН-д хүргэх улирлын явцын тайланд тусгана. Төслийн гүйцэтгэлийн тайлан хүртэл барилга угсралтын ажил, ашиглалтын эхний үе шатанд ДБ нь ГШМ-ын гүйцэтгэлийн тайланг тогтмол эсвэл хүсэлтийн дагуу байнга авч байх ёстой.

Оролцогч талуудын уулзалт. Энэ уулзалтад уригдсан хүмүүс гомдлын шинж чанараас хамаарна. Жишээлбэл, гомдол нь эрүүл мэнд, газрын маргаан, хөдөлмөрийн асуудалтай холбоотой бол холбогдох чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэнг оролцогч талуудын хуралд урина. Үүнд Газрын

агентлаг (газрын эрхийн асуудал), Эмэгтэйчүүдийн холбоо ТББ (жендерийн асуудал), Эрүүл мэндийн газар (эрүүл мэндийн асуудал), аймгийн байгаль орчны газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар (хөдөлмөрийн болон нийгмийн аюулгүй байдал, байгаль орчны асуудал эрхэлсэн ажилтнууд), болон Хөдөлмөрийн Яам, нийгмийн хамгааллын ажилтан (хөдөлмөрийн асуудал) багтана.

Хавсралт 1. Дэд төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээний маягт

Дэд төсөл гэж Малчдын цахим хоршоо төслөөс санхүүжилт авч буй төслийг хэлнэ.

А. Хүсэлт гаргагчийн мэдээлэл

Байгууллагын нэр:	
Холбогдох хүний нэр, албан тушаал:	Хаяг, утас, и-мэйл:
Дэд төсөл (үйл ажиллагааны товч мэдээлэл):	Дэд төслийн нийт өртөг:
Дэд төслийн үйл ажиллагаа явагдах байршил (аймаг, сум)	Дэд төслийн эхлэх болон дуусах хугацаа:

В. Эрсдлийн шинжилгээний асуулт ба арга хэмжээ

Асуулт	Хариулт		БОНХС-ын хамаарал	Хэрвээ тийм гэж хариулсан бол доор заасан нэмэлт материалыг ирүүлнэ үү
	Тийм	Үгүй		
Дэд төсөл нь байгаль орчинд удаан хугацааны, байнгын болон/ эсвэл эргэшгүй сөрөг нөлөө үзүүлэх үү?			БОНХС 1	Хэрэв тийм гэж хариулсан бол дэд төслийг санхүүжүүлэхгүй
Дэд төсөл нь эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг эмзэг бүлгийн хүмүүст үр шимээ өгөх үү?			БОНХС 1	Хэрэв үгүй гэж хариулсан бол төслийн загварыг сайжруулах шаардлагатай
Дэд төслийн үйл ажиллагааны улмаас түр зуурын, бага талбайг хамарсан байгаль орчны сөрөг нөлөөлөл үүсэх үү?			БОНХС 1	Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулах
Дэд төслийн хүрээнд шинээр барилга барих, өргөтгөх, хуучин барилгыг сайжруулах, нөхөн сэргээх зэрэг барилгын ажил хийгдэх үү?			БОНХС 2	Хэрэв тийм бол дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулах
Дэд төслийн хүрээнд албадан хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн бусад хортой болон мөлжлөгийн хэлбэртэй			БОНХС 2	Хэрэв тийм бол дэд төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй

холбоотой бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж ашиглагдах үү?				
Дэд төслийн хүрээнд шууд, гэрээт, анхан шатны хангамжийн болон/эсвэл олон нийтийн ажилтан зэрэг ажилтануудыг шинээр ажилд авах үү?			БОНХС 2	Дэд төслийн хөдөлмөрийн харилцааны журам боловсруулах
Дэд төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой ноцтой эрсдэл бий юу?			БОНХС 2	Дэд төслийн хөдөлмөрийн харилцааны журам, байгаль орчин, нийгмийн менежентийн төлөвлөгөө боловсруулах
Дэд төслийн үйл ажиллагаа байгалийн нөөцийг ихээр ашиглах үү?			БОНХС 3	Байгалийн нөөцийг тогтвортой ашиглах талаар арга хэмжээг төслийн загварт оруулж өөрчлөх.
Дэд төслийн үйл ажиллагааны улмаас бохирдол ихээр үүсэх үү?			БОНХС 3	Бохирдлын хэмжээг бууруулахын тулд төслийн загварт өөрчлөлт оруулах
Дэд төсөлд хүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх өндөр магадлал бий юу?			БОНХС 4	Хэрэв тийм бол дэд төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй
Дэд төсөлтэй холбоотойгоор нүүлгэн шилжүүлэх эсвэл газар чөлөөлөх/газар ашиглалтыг хязгаарлах үү?			БОНХС 5	Хэрэв тийм бол дэд төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй
Дэд төсөл нь байгаль ан амьтанд чухал газар болон байгалийн амьдрах орчинд сөргөөр нөлөө үзүүлэх үү?			БОНХС 6	Хэрэв тийм бол дэд төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй
Дэд төслийн үйл ажиллагаа орон нутгийн болон улсын тусгай хамгаалалттай газар, тэдгээрийн хязгаарлалтын бүсэд явагдах үү?			БОНХС 6	Хэрэв тийм бол дэд төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй
Дэд төслийн хэрэгжилт нь байгаль ан амьтанд чухал бус газрын байгалийн амьдрах орчинд нөлөөлөх үү?			БОНХС 6	Хэрэв тийм бол дэд төслийн нөлөөллийн үнэлгээ хийнэ
Дэд төслийн хүрээнд мал аж ахуйн үйл ажиллагаа явагдах эсэх?			БОНХС 6	Хэрэв тийм бол уг баримт бичгийн 6.4-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх
Дэд төсөл хэрэгжих бүсэд нутгийн уугуул иргэд байдаг үү, санал болгож буй дэд төслийн үйл ажиллагаа нь тэдэнд эерэгээр эсвэл сөргөөр нөлөөлөх үү?			БОНХС 7	Дэд төсөл хэрэгжих талбайд үндэсний цөөнхи, уугуул иргэд байдаг бол оролцогч талуудтай хийх

				уулзалтыг орон нутгийн онцлог, соёлд тохирсон хэлбэрээр хийх
Дэд төслийн үйл ажиллагаа нь соёлын биет өвд сөрөг нөлөө үзүүлэх үү?			БОНХС 8	Хэрэв тийм бол дэд төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй

Байгаль орчин, нийгмийн хамгааллын менежментийн төлөвлөгөө/баримт бичиг:

Тайлбар:

Гарын үсэг:

Албан тушаал:

Огноо:

Хавсралт 2. Бага хэмжээний барилгын ажилд Байгаль орчныг хамгаалах талаар тавих шаардлага

Ерөнхий шаардлага

Төслийн гүйцэтгэгч болон түүний ажилчид нь орон нутгийн иргэдэд үзүүлэх хор уршиг, хохирлоос урьдчилан сэргийлэх, барилга угсралтын болон үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах талаар заасан энэхүү шаардлагад нийцсэн сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг дагаж мөрдөнө.

Барилга угсралтын явцад үр дүнтэй хийх боломжгүй нөхөн сэргээлтийн ажлыг тухайн барилгын ажлыг дуусах явцад хийж дуусгана (барилгын ажлыг дуусган хүлээлгэн өгөхөөс өмнө). Үүнд:

- Барилгын ажлын явцад нөлөөлөлд өртсөн/ хөндөгдсөн хэсгийг тохижуулж, зүлэгжүүлж ойжуулах зэрэг шаардлагатай нөхөн сэргээх ажлуудыг хойшлуулалгүйгээр хийж дуусгах
- Усны урсгалыг хог хаягдлаас цэвэрлэсэн байх бөгөөд ус дамжуулах болон зайлуулах хоолойн урсгал чөлөөтэй эсэхийг шалгах
- Бүх хэсгийн хог хаягдлыг цэвэрлэн, илүүдэл материалыг зохих ёсоор нь зайлуулсан байх
- Хайрга шороо авсан нүхнүүдийг эргэн бөглөх

Барилгын ажил ба Гүйцэтгэгчид зориулсан байгаль орчны дүрэм

Дараах мэдээллийг үндсэн удирдамж болгон ашиглах ба орон нутгийн болон үндэсний дүрэм журмуудтай хамт хэрэглэнэ. Барилгын ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь эдгээр заалтуудыг хэрхэн дагаж мөрдөх талаар тодорхой тусгасан Барилгын Төлөвлөгөөгөө Төслийн инженер танилцуулна. Төслийн инженер энэхүү Төлөвлөгөөг баталсаны дараа барилгын ажлыг эхлүүлнэ.

Хориглох зүйлс

Барилгын талбай болон түүний орчимд дараах зүйлс хориотой. Үүнд:

- Зөвшөөрөгдсөн барилгын талбайгаас гадна аливаа шалтгаанаар мод тайрах
- Ан агнах, загасчлах, зэрлэг амьтдыг барих эсвэл ургамал түүх;
- Хар тугалга агуулсан будаг, асбест гэх мэт зөвшөөрөгдөөгүй хортой материал ашиглах
- Архитекторын болон түүхийн ховор, үнэ цэнэтэй зүйлийг нураах, сүйтгэх;
- Гал гаргах;
- Галт зэвсэг хэрэглэх (зөвшөөрөгдсөн харуул хамгаалалтаас бусад);
- Ажилтанууд архи согтууруулах ундаа хэрэглэх.

Тээвэрлэлт

Гүйцэтгэгч нь Төслийн инженертэй зөвшилцсөний дагуу төслийн талбай руу сонгосон замаар, тухайн хэсгийн замын ангилалд тохирох тээврийн хэрэгслийг ашиглан нэвтрэх ба тээврийн зорилгоор ашиглаж буй орон нутгийн зам, гүүрийг эвдрэхээс сэргийлж ачааллыг нь тохируулна. Ачаа хэтрүүлсэн тээвэрлэлтийн улмаас орон нутгийн зам, гүүрэнд учруулсан аливаа хохирлыг Гүйцэтгэгч хариуцах ба Төслийн Инженерийн зөвшөөрч баталсны дагуу тэдгээрийг засварлах үүрэгтэй.

Барилга байшин ихтэй аливаа газарт үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд бүх моторт тоног төхөөрөмжинд дуу намсгагчийг Гүйцэтгэгчийн хяналтан дор суурилуулж, зохих ёсоор ашиглана.

Барилгын Гүйцэтгэгч нь гэрээний хугацааны туршид замын хөдөлгөөнийг хянах арга хэмжээг төслийн инженерийн урьдчилан баталсны дагуу зохион байгуулж ажиллана.

Ажиллах хүч ба ажилчдын эрүүл ахуй

Барилгын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь ажиллагсдын дийлэнх олонхийг орон нутгийн иргэдээс бүрдүүлэх ба тэдгээрийг шаардлагатай сургалтад хамруулан чадваржуулсан байна.

Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллахаар төлөвлөсөн хүний тоогоор шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар (бие засах газар болон гар угаах хэсэг) хангах ёстой. Бие засах газар нь халуун, хүйтэн ус, саван болон гар хатаах төхөөрөмж зэрэг хэрэгслээр бүрэн хангагдсан байх ёстой.

Гүйцэтгэгч нь ажиллагсад байрлах байранд бохирын нөөцлүүрийг суурилуулж, засвар үйлчилгээг хийж, ойролцоох усны эх үүсвэрийг бохирдуулахгүйгээр ашиглана.

Гэрээт гүйцэтгэгч нь ажилчдын байр болон бие засах газраас гарах хатуу хог хаягдыг хадгалан, зайлуулж устгах арга, системийг бий болгож ашиглана.

Гүйцэтгэгч нь ажиллагсадын байрлах байр эсвэл төв байранд модыг халаалт болон хоол хийхэд түлшний зориулалтаар ашиглахгүй бөгөөд бусад төрлийн түлш ашигладаг байгууламжаар хангана.

Гүйцэтгэгч нь төслийн инженерийн зөвшөөрсөн талбайд албан контор, агуулах, асфальтийн цех болон засварын газрыг байгуулах бөгөөд эдгээр нь хүмүүсийн оршин суудаг суурин газраас 500м-ээс, асфальтын цех нь 1000м-ээс багагүй зайд байрших ёстой.

Гүйцэтгэгч нь албан контор, агуулах, ялангуяа дизель түлш, битум хадгалах агуулах, асфальтын цехийг усны эх үүсвэрээс 500 метрээс дотогш байрлуулахгүй ба бохирдуулагч бодис нь хөрсөөр болон ялангуяа борооны үед гүний усны шүүрэлтээр дамжин усны эх үүсвэр оруулахгүй байх нөхцлийг ханган ажиллана. Үүний тулд тосолгооны материалыг дахин боловсруулах шаардлагатай ба тухайн хэсэгт батлагдсан тунгаах цөөрөм/ гарах хэсэг дээр нь тосны шүүлтүүр бүхий шуудууг барих шаардлагатай.

Гэрээт гүйцэтгэгч нь Ажлын хэсгийг бүрдүүлж буй аливаа материалыг боловсруулах, бэлтгэх явцад болон халаах зорилгоор модыг түлш болгон ашиглах ёсгүй.

Хог хаягдалын менежмент болон газрын эвдрэл

Хатуу, ариун цэврийн байгууламжийн, аюултай хог хаягдлыг дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх замаар зохих ёсоор хянана. Үүнд:

Хог хаягдлын менежемент:

Боловсруулах эсвэл устгах хог хаягдлын хэмжээг багасгах.

Гарч байгаа хог хаягдлыг тодорхойлох ба ялган ангилах. Хэрэв ямар нэг аюултай хог хаягдал гарч байгаа бол, тэдгээрийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах хэрэгтэй.

Хог хаягдлын цэгийг тодорхойлж, зааглаж өгөх бөгөөд тухайн хэсэгт хаяж болох материалыг нь тодорхой заана.

Барилгын бүх хог хаягдлыг (газрын үхлагыг оролцуулан) батлагдсан хогийн цэгт (гол, горхи, нуур, намгархаг газраас 300м-ээс хол зайд) хаяж байгаа эсэхийг хянана. Бүх хог хаягдал, метал, ашигласан тос, болон барилгын явцад үүссэн илүүдэл материалыг зөвшөөрөгдсөн бүсэд устгах ба дахин боловсруулах систем болон материалыг ангилахтай хамт хэрэгжүүлнэ.

Газрын элэгдлийг хянах:

Аль болох бага хэмжээний газрыг хөндөх, тухайн газрыг аль болох хурдан сэргээх, тухайн хэсэг дэх ус зайлуулах сувгийг хянах, хур тунадасыг газарт нь шингээх шаардлагатай. Ухлага, хог хаягдлын нүх, автозамын хүрээний дагуу элэгдлийг хянах хаалтыг барих шаардлагатай.

Газрын өнгөн хөрсийг өвс, навчны хаягдал болон органик материалуудтай нь авч хадгалан, үүнийгээ тухайн орон нутгийн байгалийн ургамалжилтыг нөхөн сэргээх зорилгоор хөндөгдсөн газарт эргэн ашиглана.

Барилгын орчин тойрны эсвэл үржил шимгүй элэгдсэн хөрсийг нөхөн сэргээхэд орон нутгийн байгалийн төрөл зүйлийн ургамлын үр болон бордоог ашиглана.

Барилгын ажил дууссаны дараа нэн даруй, борооны улирал эхлэхээс өмнө хөрсний эвдрэлийг хянах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Барилгын бүх талбайд болон шаардлагатай хэсгүүдэд хур тунадасны урсацыг удаашруулах, чиглэлийг нь өөрчлөх, ургамалжилт бий болтол хур тунадасыг шингээх байгууламжийг барих зэргээр хур тунадасыг хянах бүтцийг суурилуулна.

Шуудуу, хашлага, хянах байгууламж, амьд өвсөн хаалт болон чулууг ашиглан барилгын талбай эсвэл хөндөгдсөн газраар дамжин өнгөрөх усны урсацыг хянана.

Ургамлан давхарга ургаж сэргэх хүртэлх хугацаанд элэгдлээс хамгаалах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх хэрэгтэй.

Шаардлагатай тохиолдолд салхины нөлөөгөөр үүсэх элэгдлийг багасгах зорилгоор шороон зам, ухлага, дүүргэх материал болон овоолсон хөрсийг усаар шүршинэ.

Засвар үйлчилгээ

Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх газрыг тодорхойлж тусгаарлах (гол, горхи, нуур, намгархаг газраас 15 м-ээс зайтай) шаардлагатай. Шатахууны агуулахыг зохих газарт байрлуулж, байрлалыг төслийн инженерээр батлуулна.

Машин механизмын тос солих зэргийг оролцуулан Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний бүх үйл ажиллагааг засвар үйлчилгээний хязгаарлалтын хэсэгт хийж гүйцэтгэнэ; хэрэглэсэн тосыг газар, усны суваг, ус зайлуулах суваг, бохир усны системд хаяж болохгүй.

Асгарсан болон цуглуулсан бүхий л газрын тосны бүтээгдэхүүнийг байгаль орчны стандарт журам/ удирдамжийн дагуу устгана. Шатахуун хадгалах болон цэнэглэх талбайг бүх дамжуулах байгууламж болон усны чухал хэсгүүдээс 300м-ээс доошгүй зайд эсвэл Инженерийн зааврын дагуу байрлуулна.

Газар шорооны ажил, Ухлага болон Өндөрлөгөө / Дүүргэлт

Барилга байгууламж барихтай холбоотой бүх төрлийн газар шорооны ажлуудад ялангуяа борооны улиралд нарийн хяналт тавьж ажиллах ёстой.

Гүйцэтгэгч нь бүх л үед ухлага болон дүүргэлтийн тэнцвэртэй байлгах хэрэгтэй ба ажлын зөвшөөрөгдсөн талбайгаас гадна хэсэгт газрыг хөндөхгүй байх хэрэгтэй.

Гүйцэтгэгч нь аливаа газарт ухах болон дүүргэх ажлыг богино хугацаанд эцсийн хөндлөн огтлолын дагуу бүрэн хийж дуусгах хэрэгтэй бөгөөд ялангуяа борооны улирлын үеэр газар шорооны ажлыг хэсэгчилж хийхээс зайлсхийхийн тулд тасралтгүй ажиллагаатай байх шаардлагатай.

Газар шорооны үед гарсан овоолгыг элэгдэл эвдрэлээс хамгаалахын тулд зураг төслийн дагуу налууны дээд ба доод хэсэгт борооны уснаас хамгаалсан шуудуй татах ба ухлага овоолгын гадаргууг ургамалжуулна.

Ухаж авсан болон тохирохгүй материалыг Төслийн Инженертэй зөвшилцсөний дагуу хог хаягдлыг зайлуулах зориулалтын бүсэд хаяна.

Хог хаягдлыг зайлуулах бүсийг цаашид хөрс нь нурах, газар тариалан, хөдөө аж ахуйн болон бусад эдэлбэрт нөлөөлөх эсвэл хогийн цэгийн хөрс угаагдаж усны эх үүсвэр рүү орох боломжтой газар байрлуулахгүй. Бохир шингэн зайлуулах хоолойг Инженерийн заасны дагуу хогийн цэгийн эргэн тойронд эсвэл дотор нь ухах шаардлагатай.

Овоолго ба хайрга шороо авсан нүх

Хуурай газар, гол, эсвэл одоо байгаа газраа өөр газраас шинээр хөрс шороо авч ашиглах тохиолдолд Төслийн инженерээс урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд Төслийн инженерийн зааварчилгааны дагуу уг үйл ажиллагааг зогсооно. Шороо чулуу авч ашиглах газар нь байгалийн болон төлөвлөсөн ус зайлуулах байгууламжинд нөлөөлөхөөр бол ашиглахыг хориглоно. Хэрэв гол мөрний эрэг нураах, эвдрэх эсвэл голын урсгалын доод хэсэгт байгаа нарийн ширхэгт материалыг авах тохиолдолд гол мөрний хэсгээс хайрга шороо авахыг хориглоно.

Гүйцэтгэгч нь хайрга шороо авч ашигласан нүх нь тэгш, цэвэрхэн, хажуугийн налуу нь бат бөх байх ба шумуул хооллодог усны биет бүхий тогтоол ус үүсэхээргүй ус зайлуулах сувагтай байна.

Голын сав газраас чулуу хайрга авсан тохиолдолд ухсан нүхний гүн нь голын өргөний аравны нэгээс бага хэмжээтэй байх ёстой ба голын урсгалыг өөрчлөх, сав газарт ямар нэг сөрөг нөлөө үзүүлээгүй байх шаардлагатай.

Хайрга чулуу бутлах төхөөрөмжийг Төслийн инженерийн батласны дагуу, байгаль орчны тогтворгүй бүс болон одоо байгаа хүн амын суурьшлын бүсээс зайтай байрлуулах бөгөөд баталгаат тоосны хяналтын төхөөрөмжтэй бутлах төхөөрөмжийг ашиглана.

Чулуу шороо авах газар болон хог хаягдлын цэгт Гүйцэтгэгч:

- Овоолго хийх, чулуу хайрга авах газрыг урьдчилан тогтоож заагласан байх ба энэ газар нь эгц налуу, элэгдэлд өртөмхий газар, усны эх үүсвэр рүү шууд цутгадаг бүсээс хамгийн багадаа 15 метрээс хол зайтай байх
- Зөвшөөрсөн, заагласан газраас авах материалын хэмжээнд хязгаар тогтоосон байна.
- Нүхийг анх ухагдаа өнгөн хөрсний шороог тусад нь овоолно. Тухайн нүхнээс ашиглах материалыг авсаны дараа өнгөн хөрсийг нүхний дээгүүр тарааж тавин тэгшлэн, гадаргууг жигд, ус зайлуулах зорилгоор налуу болгоно. Эгц налуу дэр газрын элэгдлийг хянахад зориулсан дэнж, дэвсгийг засна.
- Тухайн газрын байгалийн даацыг хэтрүүлэлгүйгээр авч ашиглах ба дараа нь ухсан газарт органик гаралтай хаягдал хийж газрыг тэгшилж, ургамалжуулна. Ургамалжуулалтад аль болох байгалийн ургамлын үр суулгац ашиглах шаардлагатай.
- Хэрэв тухайн газарт ус зайлуулах, уснаас хамгаалах зорилготой суваг шуудуу байсан бол тэдгээрийг хэвийн байдалд оруулж үлдээх ёстой.
- Барилгын ажил дуусахад талбайд байгаа хог хаягдал, үлдэгдлийг бүрмөсөн цэвэрлэж орчныг тохижуулна.

Барилгын болон тээврийн хэрэгслэлээс гарсан хог хаягдлыг зайлуулах, устгах

Гэрээт гүйцэтгэгч нь барилгын талбайг цэвэрлэхэд өдөр тутам мөрдөх дүрэм гаргаж мөрдүүлэх ба үүнд барилгын ажлаас гарах хог хаягдал тэдгээрийг зайлуулах устгах байгууламж, аргачлалыг тусгасан байна.

Хуучин байсан барилгыг буулгах тохиолдолд түүнээс гарах материалуудыг шинэ барилгын ажилд боломжийн хэмжээгээр эргүүлэн ашиглана (тухайлбал: далан, ухсан газрыг дүүргэх нэх мэт). Үлдсэн хаягдлыг төслийн инженерийн зөвшөөрсөн, заасан газарт зөөвөрлөнө. Гэрээт гүйцэтгэгч нь хог хаягдал цэгийг сонгохдоо (а) тогтоосон ойн бүс дотор байрлуулахгүй; (b) байгалийн ус

зайлуулах суваг жалганд нөлөөлөхөөргүй; ба (с) ховор болон нэн ховор ургамалд сөргөөр нөлөөлөхгүй газрыг сонгоно. Гэрээт гүйцэтгэгч нь барилгын материалын хог хаягдлыг ямар ч нөхцөлд байгалийн эмзэг бүс, орчинд хаяж булж болохгүй.

Барилгын материалын хог хаягдалыг зэргэлдээх газарт байршуулсан тохиолдолд Гүйцэтгэгч эдгээр хог хаягдлыг яаралтай цэвэрлэж, тухайн газрыг Төслийн инженерийн тавьж буй шаардлагад нийцүүлэн нөхөн сэргээж хэвийн байдалд оруулж өгнө.

Шаардлагатай тохиолдолд материалын хангамж, засвар үйлчилгээ, хог хаягдлыг ачих, цэвэрлэх зэрэг барилгын явцад хийгдэх тээвэрлэлтийг дагалдах ажилд тооцон урьдчилан төлөвлөж, Төслийн Инженерээр батлуулан зааварчилгааны дагуу Гүйцэтгэгч хэрэгжүүлнэ.

Барилгын ажлын үед мөрдөх аюулгүй ажиллагаа

Барилгын талбайд ажиллах хүмүүсийн аюулгүй байдал болон ойролцоох өмч хөрөнгийг аливаа ослоос хамгаалах нь Гүйцэтгэгчийн үүрэг юм. Гэрээт гүйцэтгэгч нь үндэсний болон орон нутгийн түвшинд мөрдөгдөх ёстой аюулгүйн ажиллагааны дүрмийн шаардлагыг биелүүлэн, аливаа осол аваараас сэргийлэх, арга хэмжээг авах ба дараах зүйлсийг анхаарч ажиллана:

- Явган хүний аюулгүй нэвтрэх замыг нягт нямбай тогтоож тодорхой тэмдэглэсэн байх ёстой;
- Барилгын талбайн ойр орчимд сургуулийн хүүхэд явдаг тохиолдолд хичээлийн цагаар замын аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах ажилтныг томилон ажиллуулна.
- Барилгын ажлын явцад явган хүмүүсийн аюулгүй байдлыг хангах үүднээс аюулгүй байдлын төхөөрөмж, замын тэмдэглэгээ, замын хөдөлгөөний тэмдэг (будаг, тавиур, тэмдгийн материал гэх мэт) –ний хэрэгслүүдээр хангана.
- Барилгын ажил эхлэхээс өмнө ажилчдыг аюулгүй ажиллагааны сургалтуудад хамруулах ёстой;
- Ажиллагсдыг хувийн хамгаалах хувцас хэрэгслээр (нүдний шил, бээлий, амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл, тоосны хамгаалалттай амны хаалт, дуулга, хурууны ган хамгаалалт болон ширэн түрийтэй гутал гэх мэт) хангаж хэрэглээнд байнгын хяналт тавьж ажиллана;
- Ажлын байран дээр байгаа химийн бодис түс бүрийн Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудсыг гарган байрлуулна.
- Бүх ажиллагсад Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудсыг уншсан байх эсвэл уншихыг шаардана. Тэдэнд болон тэдний гэр бүлийнхэнд ялангуяа жирэмсэн эсвэл гэр бүлээ төлөвлөж байгаа хүмүүст тухайн бодис, хэрэгслэлээс үүдэн гарах эрсдлийн талаар тодорхой танилцуулсан байх ёстой; Ажиллагсдыг шаардлагатай тохиолдолд эмчтэйгээ уг мэдээллийг хуваалцахыг дэмжинэ.
- Асбестийн найрлагатай материал болон бусад хортой бодисуудыг зайлуулах ажлыг тусгай сургагдсан ажилчнаар гүйцэтгүүлж устгуулна;
- Хүчтэй аадар бороо болон аливаа гэнэтийн онцгой байдлын үед бүх ажлыг түр зогсооно.
- Барилгын ажлын үед газар хөдлөлтийн чичирхийллийг тэсвэрлэхийн тулд цахилгаан болон механик тоног төхөөрөмжүүдийг бэхэлсэн байна.

Тоос тоосжилт болон дуу чимээний хяналт

Дуу чимээ болон тоос шороог бууруулахын тулд гэрээт байгуулага нь:

- Барилгын ажилтай холбоотой тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд барилгын талбайн 200 метрийн тойрог дотор гудамжинд 15 миль (25 км/цаг) болон түүнээс доош хурдтай байхаар тогтоох;
- Барилгын талбай доторх бүх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд 10 миль (15 км/цаг) болон түүнээс доош хурдтай байхаар тогтоох;
- Боломжтой бол ажиллаж байгаа тээврийн хэрэгсэл, машин механизмууд, тоног төхөөрөмжөөс гарах дүү чимээний түвшинг 90 дицбилл буюу түүнээс доош байхаар зохицуулах
- Зарим мэдрэмтгий газруудад (орон сууцны хороолол, эмнэлэг, амралтын газар гэх мэт) тогтоосноос илүү хэмжээний дүү чимээ гаргахаас урьдчилан сэргийлэхийн тулд илүү хатуу дэг журам хэрэгжүүлэх шаардлагатай байж болно.
- Ойролцоох айл өрхүүд болон албан газрууд, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст (хүүхэд, хөгшчүүл) сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийхийн тулд материалыг хуваах, тоос тоосжилт үүсгэх аливаа ажлыг бууруулна.
- Хөрс хуулах ажиллагааг тодорхой үе шаттайгаар, бага багаар гүйцэтгэх ба салхинд шороо босох, тоосонцор үүсэхээс сэргийлнэ.
- Орон сууц, худалдаа үйлчилгээний газар, цэцэрлэгт хүрээлэнтэй ойр бүс нутагт илүү анхаарал хандуулж барилгын талбайн эргэн тойронд тоосны хамгаалалтыг байрлуулна.
- Шаардлагатай тохиолдолд шороон зам, газар үхлага, хөрсний овоолго, дүүргэх материал авч буй газруудад ус шүршиж байх
- Барилгын ажлаас үүдэлтэй чичирхийлэл, дүү чимээ гаргахыг бууруулах зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Ашиглагдахгүй барилга, дэд бүтцийг буулгах үед баримтлах журам

Гүйцэтгэгч нь аливаа ашиглагдахгүй барилга байгууламжийг нурааж буулгахдаа ажиллагсад болон олон нийтийн дээрээс хог хаягдал, унах, эмтэрхий хэлтэрхийд цохиулахаас хамгаалах сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авсан байх ёстой. Эдгээр арга хэмжээнд:

- Хог хаягдал унаж болзошгүй бүсийг тогтоож, барилган дээд давхраас хог хаягдлыг аюулгүйгээр буулгах хоолой байгуулах,
- Хөрөөдөх, зүсэх, нунтаглах, зүлгэх,хагалах, цүүцлэх ажлыг зохих хамгаалалт болон шаардлагатай тохиолдолд бэхлэгээтэй хийх
- Хүнд даацын машиныг сул хог хаягдлыг дайрахаас сэргийлж замыг цэвэр байлгах,
- Барилгын эмтэрсэн хэсгүүд унахаас хамгаалах тор, түр зуурын хамгаалалтын арга хэмжээг тавцан булан бүрт байгуулах, хамгаалалтын хаалтуудыг байгуулах,
- Тэсэлгээний ажлын явцад бүх ажлын байр талбайг чөлөөлөх, хэрэв тухайн тэсэлгээний ойр орчинд хүн, оршин суугчид барилга байгууламж байвал тэсэлгээний хэлтэрхи, чулуу үсрэх эрсдлийг бууруулах зорилгоор тэсэлгээний дэвсгэр болон бусад үсрэлтийг багасгах арга хэмжээнүүдийг авч хэрэглэнэ. ,
- Бүх ажилчдын хамгаалах хажуугийн хаалттай хамгаалалтын нүдний шил, нүүрний хаалт, дуулга, болон хамгаалах гутлаар хангана.

Олон нийттэй харилцах

Олон нийттэй харилцах харьцааг зохих ёсоор дээшлүүлэхийн тулд гүйцэтгэгч нь:

- Тухайн сум орон нутгийн иргэд, олон нийтэд барилгын ажлын талаар болон ажлын хуваарь, нийтийн үйлчилгээний түр хязгаарлалт, замын хөдөлгөөний болон нийтийн тээврийн хэрэгслийн чиглэлийн өөрчлөлт, газар ухах, хуучин барилга нураах гэх мэтийн талаар тохиромжтой байдлаар урьдчилан мэдээлэх.
- Шөнийн цагаар барилгын ажил гүйцэтгэхийг хязгаарлах. Хэрэв шөнийн цагаар ажил гүйцэтгэх шаардлага гарвал нарийн хуваарь гарган олон нийтэд мэдээлэх шаардлагатай.
- Барилгын ажилтай холбоотойгоор аливаа үйлчилгээг (ус хангамж, цахилгаан, телефон холбоо таслах, автобусны хөдөлгөөн маршрут өөрчлөх гэх мэт) саатуулах тохиолдолд наандаж 5 хоногийн өмнө барилгын ажлын талбай, автобусны зогсоол, нөлөөлөлд өртөх байр/ албан байгууллагын гадна мэдээллийг байршуулах замаар олон нийтэд урьдчилан мэдэгдэнэ.

Байгаль түүх, Соёлын дурсгал илрүүлэх тохиолдолд анхаарах асуудлууд

Гүйцэтгэгч нь барилгын талбайг ухах болон барилгын үйл ажиллагааны явцад археологийн газар, түүхэн дурсгалт газар болон булш бунхан зэрэг олдвор, эд зүйлсийг олсон тохиолдолд Гүйцэтгэгч дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Олдвор олдсон хэсэг газарт барилгын үйл ажиллагааг зогсоох;
- Олдвор олдсон хэсэг эсвэл газрыг зааглан тусгаарлах;
- Зөөвөрлөж болохуйц эд зүйлсийг гэмтээх болон алдахаас сэргийлж тухайн газрыг хамгаална. Зөөвөрлөж болохуйц эртний болон ховор эд зүйл олдсон тохиолдолд Үндэсний түүх соёлын асуудал хариуцсан байгууллага, эсвэл орон нутгийн захиргааны байгууллага хүлээн авах хүртэл шөнийн харуул хамгаалалтын ажлыг зохион байгуулна ;
- Үндэсний түүх соёлын асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэх үүргийг барилгын талбайн хяналтын инженер хариуцах ба тэрээр дээрх байгууллагуудад энэ тухай 24 цагийн дотор мэдээлэх үүрэгтэй;
- Орон нутгийн захиргаа болон Үндэсний түүх соёлын асуудал хариуцсан байгууллага нь тухайн түүх, соёлын дурсгалт зүйлийг хэрхэн тухай зохих шийдвэр гаргах хүртэлх хугацаанд тэдгээрийн хамгаалалт, хадгалалтын асуудлыг хариуцна, Үндэсний түүх соёлын асуудал хариуцсан байгууллагын археологичид олдворыг урьдчилан үнэлнэ. Олдворын ач холбогдол үнэ цэнийг үнэлэхдээ гоо сайхны, түүхийн, шинжлэх ухаан болон судалгаа шинжилгээний, нийгмийн болон эдийн засгийн үнэ цэнийг багтаасан соёлын өвтэй холбоотой олон төрлийн шалгуурын дагуу үнэлнэ.
- Олдворыг хэрхэх тухай шийдвэрийг тухайн асуудал хариуцсан байгууллага болон Үндэсний түүх соёлын асуудал хариуцсан байгууллага гаргана. Энэ шийдвэрт байршлыг өөрчлөх (тухайлбал соёлын болон археологийн чухал ач холбогдолтой хөдөлгөж болшгүй олдворыг илрүүлсэн тохиолдолд), хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх болон аврах тухай заасан байна.
- Олдворыг хэрхэх талаар эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг холбогдох орон нутгийн байгуулагад албан бичгээр мэдэгдэнэ;
- Олдворыг хамгаалах асуудалд анхаарсаны үндсэн дээр тухайн орон нутгийн эрх бүхий байгууллага эсвэл Үндэсний түүх соёлын асуудал хариуцсан байгууллагаас зөвшөөрөл өгсөний дараа л барилгын ажлыг үргэлжлүүлнэ.

Хавсралт 3. Дэлхийн Банкны санал гомдол шийдвэрлэх үйлчилгээ. Санал гомдлын маягт.

Маягтыг МААЭЗЭНТ-ийн БОНХМБ-ын Хавсралт 3-аас харна уу.

<https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/171019esmf.pdf>

Хавсралт 4. COVID-19-ийн талаархи ДЭМБ-ын удирдамж

КОВИД19 –ын цар тахлын үед ДЭМБ-аас зөвлөсөн дараах арга хэмжээнүүдийг төслийн хэрэгжилтийн туршид чанд мөрдөнө.

Нийгмийн эрүүл мэндийн болон нийгмийн арга хэмжээнүүд нь халдвар дамжих гинжин хэлхээг зогсоож, дэгдэлтээс сэргийлэхэд хувь нэмрээ оруулахаас гадна ялангуяа вакцин болон эмчилгээ хараахан гараагүй үед КОВИД19-ын халдварын цаашдын тархалтыг хязгаарлахад нэн чухал үүрэгтэй. Эдгээрт дараах арга хэмжээнүүдэд багтана. Үүнд:

- **Хувь хүнд чиглэсэн арга хэмжээ** нь халдвар хүнээс хүнд дамжихыг хязгаарлаж, хувь хүнийг болон тэдний гэр бүлийг хамгаалах, хүний байнга хүрдэг гадаргуугийн халдварлалтыг бууруулна. Хувь хүнд чиглэсэн арга хэмжээнүүдэд гарын ариун цэвэр сахиу, хүн хоорондын зай барих, зөв ханиаж найтаах, хэрвээ өвчтэй бол эсвэл өвчтэй хүнтэй харьцаж байгаа бол амны хаалт хэрэглэх, орчноо цэвэрлэх болон гэр орноо халдваргүйжүүлэх зэрэг орно.
- **Хувь хүн болон олон нийтийн газар хүн хоорондын зай барих арга хэмжээ** нь халдвартай хүнээс халдваргүй хүнд халдвар дамжихаас урьдчилан сэргийлэх ба тэдгээр хүмүүст хүнд өвчин үүсэх эрсдлээс хамгаална. Эдгээр арга хэмжээнүүдэд хүн хоорондын зай барих, хүн ам олноор цугларах арга хэмжээг цуцлах эсвэл багасгах, хүн ихтэй янз бүрийн байгууламжаас зайлсхийх (нийтийн тээвэр, ресторан, бар, театр гэх мэт), гэрээсээ ажиллах, гэртээ байх, ажлын байр болон боловсролын байгууллагын өөрчлөлтийг дэмжих зэрэг хамаарна. ДЭМБ-аас хүнээс хүнд халдвар дамжих эрсдэлийг бууруулахын тулд хүн хоорондын зайг хамгийн багадаа 1 метрээс багагүй байхыг зөвлөсөн.
- **Хөдөлгөөн хязгаарлах арга хэмжээ** нь вирус тухайн бүс нутагт орж ирэхээс урьдчилан сэргийлэх, нэг бүсээс нөгөө бүс рүү вирус шилжихийг хязгаарлахад чиглэдэг. Эдгээр арга хэмжээнд орон нутгийн болон улсын хэмжээнд хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, аялалын талаар заавар зөвлөгөө өгөх, галт тэрэгний болон автобусны буудал, онгоц зэрэг аялалын төвүүд дэх бөөгнөрлөөс зайлсхийхийн тулд урьдчилан төлөвлөж аялалыг зохион байгуулах болон КОВИД 19-ын орон нутгийн тархвар зүй дээр үндэслэн бүсчилсэн халдваргүйжүүлэлт болон бусад сонгосон арга хэмжээнүүд хамаарна.
- **Хамгаалах өвөрмөц арга хэмжээнүүд** нь хүн амын өвөрмөц болон эмзэг бүлгийн иргэдийг хамгаалахад чиглэсэн байна. Үүнд:
 - КОВИД19-ын улмаас эрүүл мэндийн байдал хүндрэх эрсдэлтэй хүмүүс (ахмад насныхан, бусад суурь өвчтэй гэх мэт)
 - Нийгэм хамгааллын эмзэг бүлгийнхэн болон иргэд (цагаач ажилтанууд, дүрвэгсэд, нүүлгэн шилжүүлсэн иргэд, орон гэргүйчүүд гэх мэт)
 - Хаалттай байгууламжинд амьдарч байгаа иргэд болон бүлгүүд (удаан хугацааны амьдрах байгууламж, хорих байрууд, хуаран, хуаран төст байгууламж гэх мэт)

- Ажил мэргэжлийн улмаас вирүсийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй хүн болон иргэд (байгууллагын ажилтнууд, эрүүл мэндийн ажилтанууд, тэргүүн эгнээнд ажиллах ажилтанууд гэх мэт) Эрүүл мэндийн байгууллага болон асрамжийн газрын ажилтануудыг хамгаалах нь эрүүл мэндийн болон ахмад настны асрамжийн газарт дэгдэлт үүсэхээс сэргийлнэ.